# ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(2025 оны жилийн эцсийн байдлаар)*

2026.02.09 Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яам /цаашид яам гэх/-ны 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, “Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

## Хоёр. Танилцуулга

Зам, тээврийн яамны 2025 оны үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, Байгууллагын ажилтан албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, ерөнхий дүнг Хүснэгт №1-д харуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-д заасан тайлангуудыг яамны газар хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч, хяналт-шинжилгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус тайлагнаж ажилласан.

Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ын дагуу яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлгээний дүнг нэгтгэн, санал зөвлөмж өгч ажилласан.

*Зам, тээврийн яамны 2025 оны*
*үйл ажиллагааны ерөнхий дүн*

*Хүснэгт №1*

| № | Үзүүлэлт | | Арга хэмжээний тоо | Хэрэгжилт /Хувиар/ | Жингийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бодлогын үр дүн | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт | 54 | 65.3 | 13.06 |
| 2 | | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт | 53 | 60.4 | 12.08 |
| 3 | Чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ) | Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт | 90 | 80.4 | 16.08 |
| 4 | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 585 | 89 | 17.08 |
| 5 | | Сайдын тушаалын хэрэгжилт | 522 | 87.8 | 8.78 |
| 6 | | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт | 526 | 95.8 | 9.58 |
| 7 | Чадамжийн үнэлгээ | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ | 46 | 93.6 | 9.36 |
| 8 | | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 178 | 92.1 | 9.21 |
| 9 | | Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт | 492 | 77.4 | 7.74 |
| 10 | | Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | - | - | - |
| 11 | | Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт | - | - | - |
| 12 | | Байгууллагын ажилтан албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт | 7 | 95.7 | 9.57 |
| Нийт | | | **2553** | **83.8** | **80.9** |

## 2.1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ, хийх журам"-ын дагуу үнэлэхэд зам, тээврийн сайдын дангаараа хэрэгжүүлэх 54 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 65.3 хувь, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн өссөн дүн 45.9 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн нийт үнэлгээ 100 хувь, хөтөлбөрийн үр дүн 85.6 хувийн үнэлгээтэй байна. Мөн хөтөлбөрийн холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 26 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.2 хувийн үнэлгээтэй байна.

Төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг үнэлж, Засгийн газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д байршуулж, 0-29 хувьтай буюу "үр дүн гараагүй" төсөл, арга хэмжээг энэхүү бодлогын баримт бичигт хийсэн хяналт-

шинжилгээ, үнэлгээний тайлангийн Хүснэгт №1-т, 30-59 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүн хангалтгүй” арга хэмжээг Хүснэгт №2-т тус тус тайлагнасан байна.

Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд туссан, шалгуур үзүүлэлтийг “барилгын ажлын гүйцэтгэлийн хувь”-аар тооцохоор батлагдсан 16 төсөл, арга хэмжээ нь одоогоор ТЭЗҮ боловсруулах, зураг төсөл боловсруулах болон худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна.

Иймд эдгээр 16 төсөл, арга хэмжээг “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалын дагуу үнэлэх боломжгүй байгаа тул хэрэгжилтийн явцыг харгалзан 30-59 хувиар үнэлэв.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан 54 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэн, хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №2-т харуулав.

*Төсөл, арга хэмжээний биелэлт*
*(Хариуцсан газраар)*

*Хүснэгт №2*

| Д/д | Газруудын нэр | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|
| 1 | БТГ | 2 | 65% |
| 2 | АЗБЗГ | 32 | 62.7% |
| 3 | ТЗТБЗГ | 9 | 45.6% |
| 4 | ИНБЗГ | 7 | 80% |
| 5 | АТБЗГ | 4 | 100% |
| Нийт | | **54** | **65.3** |

*Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хариуцан хэрэгжүүлэх газар, нэгж, байгууллагыг тодорхой болгоогүй байгаа тул үндсэн чиг үүргийн дагуу Хүснэгт №2-т заасан байдлаар үнэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.5-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №3-т харуулав.

*Бодлогын баримт бичгийн*
*хэрэгжилтийн үнэлгээ*
*(Хариуцсан газраар)*

*Хүснэгт №3*

| Д/д | Газруудын нэр | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц зорилтот түвшин: 85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй” | 60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа” | 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” | 0-29 хувь буюу “үр дүн гараагүй” | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БТГ | 2 | 1 | - | 1 | - | 65% |
| 2 | АЗБЗГ | 32 | 10 | 7 | 12 | 3 | 62.7% |
| 3 | ТЗТБЗГ | 9 | 2 | - | 7 | - | 45.6% |
| 4 | ИНБЗГ | 7 | 5 | - | 2 | - | 80% |
| 5 | АТБЗГ | 4 | 4 | - | - | - | 100% |
| | **Нийт** | **54** | **22** | **7** | **22** | **3** | **65.3** |

*Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn*

## 2.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу үнэлэхэд 53 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60.46 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 100 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 81.77 хувь, тэргүүлэх чиглэлийн 15 зорилтын хэрэгжилт 62.3 хувийн үнэлгээтэй байна.

Төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг үнэлж, Засгийн газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д байршуулж, 0-29 хувьтай буюу “үр дүн гараагүй” төсөл арга хэмжээг энэхүү бодлогын бичиг баримтын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн Хүснэгт №1-т, 30-59 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүн хангалтгүй” арга хэмжээг Хүснэгт №2-т тус тус тайлагнасан байна.

Мөн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан, шалгуур үзүүлэлтийг “барилгын ажлын гүйцэтгэлийн хувь”-аар тооцохоор батлагдсан 20 төсөл, арга хэмжээ нь одоогоор ТЭЗҮ боловсруулах, зураг төсөл боловсруулах болон худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна.

Иймд эдгээр 20 төсөл, арга хэмжээ болон “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд туссан 2 төсөл, арга хэмжээг “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалын дагуу үнэлэх боломжгүй байгаа тул хэрэгжилтийн явцыг харгалзан 30 хувиар үнэлэв.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан 51 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Төрийн нарийн бичгийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу хариуцсан газруудын хүрээнд үнэлж, Хүснэгт №4-т харуулав.

*Төсөл, арга хэмжээний биелэлт*
*/Хариуцсан газраар/*

*Хүснэгт №4*

| Д/д | Хариуцсан газар | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | АЗБЗГ | 2 | 38 | 65.1% |
| 2 | ТЗТБЗГ | 1 | 6 | 40.7% |
| 3 | ИНБЗГ | 1 | 6 | 53.3% |
| 4 | АТБЗГ | 1 | 1 | 100% |
| | Нийт | **6** | **51** | **60.4%** |

*Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn*

Төрийн нарийн бичгийн даргын баталсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээний төсөл, арга хэмжээг хариуцах газар, нэгж, байгууллагыг тодорхойлоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.5-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №5-т харуулав.

*Төсөл, арга хэмжээний биелэлт*
*/Хариуцсан газраар/*

*Хүснэгт №5*

| Д/д | Газруудын нэр | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц зорилтот түвшин | | | | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй” | 60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа” | 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” | 0-29 хувь буюу “үр дүн | |

| | | | | | | гараагүй” | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | АЗБЗГ | 38 | 16 | 2 | 18 | 2 | 65.1% |
| 2 | ТЗТБЗГ | 6 | 1 | - | 5 | - | 40.7% |
| 3 | ИНБЗГ | 6 | 2 | - | 4 | - | 53.3% |
| 4 | АТБЗГ | 1 | 1 | - | - | - | 100% |
| Нийт | | 51 | 20 | 2 | 27 | 2 | 60.4% |

## 2.3.Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 37 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 23 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ, хэрэгжилт тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж үнэлгээ **80.4** хувьтай байна. Үүнээс хариуцсан нэгж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээр /давхардсан тоогоор/ хэрэгжилтийг гаргаж, Хүснэгт №6-д харуулав.

*Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ*

*Хүснэгт №6*

| Д/д | Хариуцсан нэгжийн нэр | Арга хэмжээний тоо | Хэрэгжилт /хувиар/ | | | | | | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | ТЗУГ | 12 | 6 | 3 | 1 | - | 2 | - | 83.3 |
| 2 | БТГ | 17 | 9 | 2 | 1 | 1 | 3 | 1 | 75.9 |
| 3 | АЗБЗГ | 12 | 4 | 5 | 1 | - | 2 | - | 81.7 |
| 4 | АТБЗГ | 16 | 4 | 7 | 2 | - | 3 | - | 78.8 |
| 5 | ТЗТБЗГ | 13 | 4 | 1 | 4 | 3 | 1 | - | 73 |
| 6 | ИНБЗХ | 10 | 3 | 2 | 3 | 1 | 1 | - | 77 |
| 7 | ХШҮДАГ | 7 | 5 | 1 | 1 | - | - | - | 94.3 |
| 8 | СХГ | 5 | 3 | 1 | 1 | - | - | - | 92 |
| Нийт | | **90** | **37** | **23** | **12** | **6** | **11** | **1** | **80.4** |

Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд багцалж, төлөвлөсөн дараах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.Тухайлбал:

*а/ Бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ:*

- Арга хэмжээ 3.1.1. Хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох төслүүдийг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд Хашаатын цав-Хавиргын боомт чиглэлийн 96.4 км авто зам, Эрээнтолгой-Бичигт чиглэлийн 101.3 км авто зам;
- Арга хэмжээ 4.6. Орон нутгийн нисэх буудлуудыг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд “Гурвансайхан”, “Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд;
- Арга хэмжээ 4.9. Олон улсын нисэх буудлыг өргөтгөх, ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах зорилтын хүрээнд "Чингис хаан" нисэх буудлын өргөтгөл хийх, ТЭЗҮУС боловсруулах, санхүүжилтийг эрэлхийлэх арга хэмжээ, “Шинэ Хархорум” нисэх буудал байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах арга хэмжээ:

б/ Эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээ:

- Арга хэмжээ 8.1. Салбарын хуулиудыг шинээр болон шинэчлэн боловсруулах зорилтын хүрээнд Тээврийн ерөнхий хууль, Авто тээврийн тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулах арга хэмжээ;

- Арга хэмжээ 9.4. Салбарын техникийн зохицуулалт, норм, стандартыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Автотээврийн хэрэгслийн талаарх техникийн зохицуулалтыг боловсруулах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Мөн Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг Хүснэгт №7-д харуулав.

*Хэрэгжилт хангалтгүй*
*арга хэмжээний жагсаалт*

*Хүснэгт №7*

| № | Арга хэмжээний заалт, агуулга | Хүрэх түвшин | Хугацаа | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| *“0” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ* | | | | | |
| 1 | Арга хэмжээ 9.3. Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. | Эхний хагас жил: Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 40-өөс доошгүй хувьд хүргэнэ. Жилийн эцэс: Төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ. | I-IY | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2025 оныг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан ССАЖЗЯ-наас ирүүлсэн хөтөлбөрт 2024.12.12-ны өдрийн 03/2180 дугаартай албан бичгээр санал боловсруулан хүргүүлсэн. Мөн Зам тээврийн салбарын залуучуудын зөвлөлтэй хамтран "Зам, тээврийн салбарын залуу ажилтныг дэмжих хөтөлбөр" боловсруулан Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. | 0 |
| *“30” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ* | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.2.4 1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээрийг шинэчлэн байгуулна. | Эхний хагас жил: Хоёр тал хэлэлцээрийн төслийг тохирсон тухай протокол байгуулна. Жилийн эцэс: Хэлэлцээр байгуулна. | I-IY | БНХАУ-ын Чиндао хотноо 2025 оны 06 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд зохион байгуулах Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ТЗХАБ)-ын Сайд нарын 52 дугаар чуулганы үеэр БНХАУ-ын Улсын Төмөр замын газрын даргатай уулзалт зохион байгуулж хэлэлцээрийн төслийг тохирсон тухай протокол байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр ажиллаж байна. Төмөр замын газар нь БНХАУ-ын Улсын төмөр замын газартай 2025 оны 6, 7 дугаар сард 2 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Төслийг эцэслэн тохиролцох зорилгоор ТЗГ-ын 2025.06.19-ний 01/77 дугаартай албан бичгээр Монголын талын санал тусгагдсан "Хилийн төмөр замын хэлэлцээр"-ийн төслийг Хятадын талд хүргүүлсэн. 2025 оны 9 дүгээр сарын байдлаар хятадын талаас хэлэлцээрийн төслийг хүлээн авч, холбогдох яам, хороодуудаас санал авах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд талуудын солилцсон төсөлд агуулгын өөрчлөлт оруулахгүй, бага зэргийн үг найруулгын чанартай засвар хийгдэх магадлалтай байгаа талаар хариу мэдэгдсэн. Монголын талд | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг бэлтгэж, Зам, тээврийн сайдын 2025.08.05-ны өдрийн 01/3556 дугаартай албан бичгээр яамдуудаас санал авахаар хүргүүлсэн. Дийлэнх яамдууд дэмжсэн хариу ирүүлсэн бол ГХЯ, СЯ-ны зүгээс УИХ-аар соёрхон батлах гэрээ гэж үзэхээр байгааг анхаарах саналыг ирүүлсэн байна. | |
| 2 | Арга хэмжээ 2.1.3 Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх мэргэшсэн жолоочийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Эхний хагас жил: Мэргэшсэн жолоочийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан батлуулна.<br>Жилийн эцэс: Мэргэшсэн жолоочийн сургалтыг шинэчилсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. | I-IY | Мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн төслийг олон улсын жишигт нийцүүлэн дахин боловсруулсан. Төслийг батлуулахаар газар хэлтсийн дарга нар, ТНБД-д 2025.08.02-ны өдөр танилцуулсан боловч дахин боловсруулах үүрэг өгөгдөж, буцаагдсан болно. Удирдлагаас өгөгдсөн үүргийн дагуу журмын төслийг шинэчлэн боловсруулж, газар хэлтсийн дарга нарт танилцуулахад бэлэн болсон. | 30 |
| 3 | Арга хэмжээ 2.1.4 Нийтийн зорчигч тээвэр, улс хоорондын ачаа тээврийн EURO IV-V стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. | Эхний хагас жил: Хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ. | I-II | Нийтийн зорчигч тээврийн автобусны хувьд:<br>Нийтийн зорчигч тээврийн зориулалттай 24 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай автобусыг гаалийн болон НӨАТ-аас 2025-2027 онуудад (3 жил) чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан 01/760 дугаар албан бичгээр 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсэн. НЗД-аас дэмжсэн тухай хариуг 01/1193 дугаар албан бичгээр 2025.02.24-ны өдөр тус яаманд ирүүлсэн.<br>Мөн уг асуудлаар “Дэмжлэг хүссэн тухай” 01/1210 дугаар албан бичгийг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд 2025.03.20-ны өдөр хүргүүлсэн.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан, санал авахаар 01/2300 дугаар албан бичгийг 2025.05 20-ны өдөр ХЗДХ-ийн Сайд, Сангийн сайд нарт хүргүүлсэн.<br>Сангийн сайдаас 01/5133 дугаар албан бичгээр 2025.05.30-ны өдөр өмнөх хуулийн хэрэгжилт, үр дүнг тооцох, эдийн засгийн нөхцөл байдлыг судлан дахин авч үзэх тухай санал ирүүлсэн.<br>Ачааны автомашины хувьд:<br>2025 оны жилийн эцсийн байдлаар, Монгол Улсад ашиглаж байгаа бензиний 11.7 хувь, дизель түлшний 10.5 хувь нь “Евро-5” стандартын шаардлагыг хангасан шатахуун байна.<br>EVRO IV, V хөдөлгүүртэй, стандартын шаардлага хангасан ачаа тээврийн хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор ачаа тээвэрлэлтийн үйлчилгээнд ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдийн зориулалт, хөдөлгүүрийн ангилал, ашиглалтын байдалд нарийвчилсан эдийн засгийн тооцоолол хийх чиглэлийг “АТҮТ” ТӨҮГ, Нийтийн Тээврийн бодлогын газарт 2025 оны 07/2533 дугаартай албан бичиг хүргүүлсний дагуу холбогдох тооцоо судалгааг хийсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар тэмдэглэлийн 7 дахь заалтаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин зэргийг хязгаарлах шийдвэр гаргасны дагуу нийтийн тээврийн автобус болон ачааны автомашиныг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудал зогсонги байдалд ороод байна. | |
| 4 | Арга хэмжээ 3.4.3 "Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд ээлжит болон их засварын ажлыг эхлүүлнэ. | Эхний хагас жил:<br>6 чиглэлд улсын чанартай 361 км авто зам болон 878 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлыг эхлүүлнэ.<br>Жилийн эцэс:Авто зам, гүүрийн их засварын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ. | I-IY | Улаанбаатар - Өндөрхаан чиглэлийн 68 км авто замын их засварын ажил, Арвайхээр – Баянхонгор чиглэлийн 35 км авто замын их засварын ажил, Өндөрхаан – Чойбалсан чиглэлийн 50 км авто замын их засварын ажил, Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн 105 км авто замын ээлжит болон их засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025.06.04-ний өдөр, Хархорин – Цэцэрлэг чиглэлийн 40 км авто замын ээлжит болон их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025.10.08-ны өдөр, Цэцэрлэг – Тосонцэнгэл чиглэлийн 50 км авто замын ээлжит болон их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025.10.31-ний өдөр гэрээ байгуулан тус тус ажлыг эхлүүлсэн. Сангийн яамнаас тус гэрээт ажлуудын 10 хувьтай тэнцэх санхүүжилтийг 2025 онд тавьсан бөгөөд тус санхүүжилтийг урьдчилгаа төлбөрт олгосон. Урьдчилгаа төлбөрөөр зураг төслийг шинэчлэх, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах, нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэж байна.<br>Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум хүртэлх 16 км авто замын Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй тул дахин зарлах зөвшөөрөл авахаар Дэлхийн банканд хүргүүлсэн.<br>Нийт төслийн хүрээнд хэрэгжих их засварын ажлын гүйцэтгэл 10%-тай явагдаж байна. | 30 |
| 5 | Арга хэмжээ 3.4.5 Алтанбулаг-Замын-Үүд чиглэлийн авто | Эхний хагас жил:<br>Алтанбулаг-Замын-Үүд | I-IY | Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн авто замыг камержуулах ажлын тендерийг 2025 оны 03 дугаар сарын | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | замд хяналтын цахим систем нэвтрүүлнэ. | чиглэлийн авто замд хяналтын цахим систем нэвтрүүлнэ. Жилийн эцэс: Төслийг хэрэгжүүлнэ. | | 14-ны өдөр зарласан. Тендер амжилтгүй болсон. Дахин зарлах бэлтгэл ажил хангаж байна. Мөн түүнчлэн үнэлгээний хороонд өөрчлөлт оруулсан. | |
| 6 | Арга хэмжээ 4.8 Бусийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн барилгыг ашиглалтад оруулна. | Эхний хагас жил: Барилгын үлдсэн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. Жилийн эцэс: Барилгыг байнгын ашиглалтад хүлээн авна. | I-IY | 2025.03.20-ны өдөр 0325/2025 дугаар бүхий бүртгэлээр шинэчлэн боловсруулсан төсөвт магадлал хийж, баталгаажуулсан. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх 2025.02.27-ны өдөр 192/ШШ2025/01693 дугаартай шийдвэр гаргасан. Уг шийдвэрээр 5.1 тэрбум төгрөгийг “Үүрэг трейд” ХХК-аас гаргуулан Иргэний нисэхийн ерөнхий газарт төлүүлэхээр шийдвэрлэсэн. Зам, тээврийн сайдын 2025.01.22-ны өдрийн “2025 оны орлого зарлагын төлөвлөгөө батлах тухай” Х/17 дугаар тушаалын дагуу “ИНҮТ” ТӨХХК-ийн өөрийн орлогоос санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 7.5 тэрбум төгрөг суулгаж батлуулсан. Тус барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2025.04.11, 2025.05.20, 2025.08.01, 2025.10.03-ны өдрүүдэд зарласан боловч бүгд амжилтгүй болсон. Иймд тендерийг дахин энэ оны 11 сарын 13-ны өдөр зарласан бөгөөд 12 дугаар сарын 05-ны өдөр нээхээр төлөвлөсөн боловч удаа дараа амжилтгүй болсон шалтгаанаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлээд байсан эрхийг “ИНҮТ” ТӨХХК буцаан авч дээрх тендер хүчингүй болсон. Одоогоор тендерийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, шалгаруулалтыг ирэх долоо хоногт багтаан дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| 7 | Арга хэмжээ 5.2.1 Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулна. | Эхний хагас жил: Зураг төсөл хийлгэх хөрөнгийг шийдвэрлүүлнэ. Жилийн эцэс: Хөрөнгийг шийдвэрлэсний үндсэн дээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна. | I-IY | Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн төлөвлөгөөнд нийт 8 ажил тусгагдсан ба 91%-тай гүйцэтгэсэн.Зам тээврийн сайдын 2024 оны А/259 дугаар тушаалаар байгуулагдсан “Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах” ажлын хэсгийн анхдугаар хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж, ажлын хэсгийн гишүүдийн саналуудыг нэгтгэн “Хил дамнасан усан боомт байгуулах боломжгүй ба усан замын зогсоол байгуулж, хил орчмын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх бүрэн боломжтой” гэх нэгдсэн дүгнэлтийг гарсан. Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдаан 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж Монгол улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хилийн усны | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамтарсан комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх санал гарсныг албажуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/570 тоот албан бичгийг хүргүүлсэн.Нэгдсэн санал, дүгнэлтийг Монгол Улсын хилийн боомтын захиргаанд 2025 оны 03/3796 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. | |
| 8 | Арга хэмжээ 6.2 Логистикийн төв байгуулах төслүүдийг эрчимжүүлнэ. | Эхний хагас жил: Хөшигийн хөндий, Чойбалсан логистикийн төвийн санхүүжилтийг шийдвэрлэх саналыг хөгжлийн түншүүдэд хүргүүлнэ. Жилийн эцэс: Орон нутагт байгуулах логистикийн 3 төвийн ТЭЗҮ-г хийнэ. | I-IY | Олон улсын тээвэр логистикийн төв байгуулах төслийг хэрэгжүүлэх саналыг АХБ-ны 2025 оны 01 дугаар сарын 22 болон 02 дугаар сард хийсэн сайд, ТНБД болон БТГ-тэй хийсэн уулзалтуудад тавьсан бөгөөд АХБ-ны зүгээс УИХ-аар батлуулах санхүүжилтийн хэлэлцээрт тусгах саналыг СЯ-д хүргүүлж хэлэлцээрт тусгуулах талаар мэдэгдсэн. Үүний дагуу олон улсын тээвэр логистикийн төвийн санхүүжилтийг шийдвэрлэх, хэлэлцээрт тусгах саналыг СЯ-д 2025 оны 01/1065 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Чойбалсан логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах санхүүжилтийг 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг ТНБД-аар батлуулан 2025 оны 04/2047 дугаартай албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт, хувийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн. | 30 |
| 9 | Арга хэмжээ 6.3 Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулна. | Эхний хагас жил: ЭЗХЯ-тай хамтран ТХХТ-ээр хэрэгжүүлэх шийдвэр гаргуулж, сонгон шалгаруулалт зарлана. Жилийн эцэс: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлнэ. Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүргэнэ. | I-IY | МУ-ын Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолд заасны дагуу түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг уг тогтоолоор баталсан журмын хавсралт маягтын дагуу бэлтгэж, холбогдох хууль, журмын дагуу Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр холбогдох саналыг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг мэдээлэл, танилцуулгын хамт 03/1129 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлээд байна. Үүнтэй холбогдуулан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журмын 2.3.2, 2.3.3, 2.3.4-т заасан мэдээллийг нэмэлтээр цахим шуудангаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>Эдийн засгийн хөгжлийн яамнаас түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянаж, түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгохоор хүлээгдэж байна. | 30 |
| 10 | Арга хэмжээ 8.3 Олон Улсын конвенцод нэгдэх хуулийн төслийг боловсруулна. | Эхний хагас жил: “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2022 | I-IY | БТГ: “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2022 оны оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг хянан баталгаажуулахаар ХЗДХЯ-нд | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | оны оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг хянан баталгаажуулна.<br>“Олон улсын далайн байгууллагын тухай” конвенцын 2021 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br>Жилийн эцэс:<br>“Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2022 оны оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барина.<br>“Олон улсын далайн байгууллагын тухай” конвенцын 2021 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барина. | | хүргүүлэхээр дарга нараар хянагдаж байна.<br>“Олон улсын далайн байгууллагын тухай” конвенцын 2021 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг хянан баталгаажуулсан ба соёрхон батлах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан хамтран батлуулахаар ГХЯ-нд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 01/5635 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| 11 | Арга хэмжээ 10.4 Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө үнэлэх цахим систем нэвтрүүлнэ. | Эхний хагас жил:<br>Цахим системийг нэвтрүүлнэ.<br>Жилийн эцэс:<br>- | I-II | Холбогдох газруудтай бэлтгэлийг хангаж байна. | 30 |
| *“50” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ* | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.1 Хил дамнасан төмөр замуудын барилгын ажлыг эхлүүлэх, эрчимжүүлнэ.<br>Гашуун сухайт-Ганцмод боомт | Эхний хагас жил:<br>Барилгын ажлыг эхлүүлж 10 хувьд хүргэнэ.<br><br>Жилийн эцэс:<br>Барилгын ажлыг эхлүүлж 30 хувьд хүргэнэ. | I-IY | УИХ-ын чуулганы хуралдаанаар 2024.12.27-нд “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолыг батлуулсан.<br>- 2025.02.14-ний өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг холбох Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронды хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурсан.<br>- Хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | худалдан авах ажиллагааны газар дээр зохион байгуулж "БНХАУ-ын Төмөр замын барилгын инженерингийн товчоо групп" компани шалгарсан.<br>- Барилгын ажлын нээлтийн үйл ажиллагааг 2025.05.14-ний өдөр Хятадын талтай хамтран зохион байгуулсан.<br>Төмөр замын барилга угсралтын ажлын гэрээг шалгарсан гүйцэтгэгчтэй 2025.06.09-ний өдөр байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК, "ТТЗ" ХХК, БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК нар санхүүжилтийн гурван талт гэрээг байгуулж, 2025.09.01-ний өдөр урьдчилгаа 30% төлбөрийг шилжүүлсэн.<br>2025 оны 12 дугаар сарын байдлаар төслийн бэлтгэл ажлын хүрээнд гүүрийн барилгын ажлын хаалттай бүсийг байгуулж, хашаалж, камержуулсан, оффис, ажилчдын кемп, хил, гаалийн хяналтын барилга, бараа материал, техник, тоног төхөөрөмж зөөвөрлөх, хадгалах зам, талбай, бетон узель, шинжилгээний лаборатори зэргийг барьж байгуулсан. Гүүр, хоолойн барилгын ажлыг эхлүүлж нийт 289 баганан тулгуур барихаас хилийн бүсэд байрлах 2 багана, 2376 баганан тулгуурын шон суурь өрөмдөхөөс 341-ийг өрөмдөж, БНХАУ-аас бетон зөөвөрлөн цутгасан. | |
| | Шивээхүрэн-Сэхээ | Эхний хагас жил:<br><br>Барилгын ажлыг 100 хувьд хүргэнэ.<br>Жилийн эцэс:<br>Хил дамнасан төмөр замыг бүрэн ашиглалтад оруулж тээвэрлэлт эхлүүлнэ. | | Монгол Улсын Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг, Шивээхүрэн боомтын нутаг дэвсгэрт Засгийн газрын 2018 оны 232 дугаар тогтоолын дагуу баригдсан "Хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын төсөл"-ийн Шивээхүрэн өртөөний ПК0+000-Пк5+823 хүртэлх гол зам, хажуугийн 2, 3, 4, 5-р зам, 6, 7, 8, 9, 10, 11-р мухар зам, дагнасан хэрэглээний Н1, Н2, Н3, Н4-р зам нийт-19.2км доод болон дээд бүтэц, дохиолол холбоо, ачиж буулгах терминалын талбай, гэрэлтүүлгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.03-ны өдрийн 118 тоот тушаалаар байгуулагдсан комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авч 2024.12.20-ны өдрийн 2024/24 дугаар актаар баталгаажуулж байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Боомтын захиргааны алба хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хурлын протоколын 1.5 дахь заалтад "Монгол, Хятадын хил дамнасан төмөр замын төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Монголын Өөртөө Засах Орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд оруулах" талаар туссан. БНХАУ-ын талаас хоёр улсын Засгийн газар хооронд хэлэлцэн тохиролцсоны дагуу Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг Өвөр Монголын Өөртөө Засах Орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тусгах чиглэлээр идэвхтэй ажиллахаа илэрхийлэв" гэсэн. Зам, тээврийн сайдын 2025.05.23-ны өдрийн 01/152 дугаар албан бичгээр Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхээр хүсэлтийг БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороонд Гадаад харилцааны яамаар дамжуулан илгээсэн.<br>2025.06.05-ны өдөр хоёр улсын Төмөр замын газрын даргын түвшний уулзалтыг зохион байгуулж, тус уулзалтаар ШХ-СХ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтын асуудлаар хамтран ажиллах талаар нэгдсэн ойлголтод хүрч, тохиролцсон. БНХАУ-ын Улсын төмөр замын газарт 2025.06.19-ний өдрийн 01/77 дугаартай албан бичгээр Монгол, Хятадын Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замыг холбох асуудлыг дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал, эдийн засгийн үр өгөөж, ач холбогдлыг харилцан судлах, хилийн боомтуудыг эрэмбэлэн, үе шаттай төлөвлөн бүтээн байгуулах ажлын хүрээнд судалгааны ажлыг зэрэг эхлүүлэх, хамтарч урагшлуулах зэрэгт дэмжлэг үзүүлэх хүсэлт хүргүүлсэн.<br>Төслийн ажлын явцын талаар ЗГ-ын хуралдаанд танилцуулж, ЗГ-ын 2025.11.12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр төслийн ажлыг эрчимжүүлэхээр даалгасан. БНХАУ-ын Бээжин хотноо 2023 оны 10 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Бүс ба зам" дээд түвшний чуулга уулзалтын үеэр байгуулсан санамж бичгийн дагуу Ажлын хэсэг байгуулах байгуулахаар ЭЗХС-ын тушаалын төсөл, танилцуулгыг боловсруулж, ЗТС-ын 2025.12.04-ний өдрийн 01/5622 дугаар бичгээр хүргүүлээд байна. | |
| | Ханги-Мандал боомт | Эхний хагас жил: Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр замын ачаа тээврийн үр ашгийг тооцож, Хятадын талтай хийх яриа, | | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр баталсан "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцээг эхлүүлнэ.<br><br>Жилийн эцэс: Ханги-Мандал боомтыг 2004 оны Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт тусгана. | | үндсэн чиглэл батлах тухай" 58 дугаар тогтоолын 10 дугаар зүйлд "Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч зэрэг боомтыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх" гэж даалгасан.<br>2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг байгуулсан.<br>Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Боомтын захиргааны алба хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсэг (цаашид ажлын хэсэг гэх)-ийн I улирлын хурал 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд тус хурлын протоколын 1.5 дахь заалтад "Монгол, Хятадын хил дамнасан төмөр замын төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд оруулах" талаар туссан.<br>Хятадын талаас хоёр улсын Засгийн газар хооронд хэлэлцэн тохиролцсоны дагуу Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг Өвөр Монголын Өөртөө Засах Орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тусгах чиглэлээр идэвхтэй ажиллахаа илэрхийлэв" гэснийг үндэслэн "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол улсын Засгийн газар, БНХАУ-н Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээр"-т Ханги-Мандал төмөр замын боомтыг нэмж тусгах асуудлыг шийдвэрлэхээр хүлээгдэж байна.<br>2025.06.05-ны өдөр хоёр улсын Төмөр замын газрын даргын түвшний уулзалтыг зохион байгуулж, тус уулзалтаар ШХ-СХ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтын асуудлаар хамтран ажиллах талаар нэгдсэн ойлголтод хүрч, тохиролцсон.<br>БНХАУ-ын Улсын төмөр замын газарт 2025.08.06-ны өдрийн 01/212 дугаартай албан бичгээр "Монгол, Хятадын Ханги-Мандал боомтын төмөр замыг хамтран барих тухай Монгол Улсын Төмөр | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | замын газар болон БНХАУ-ын Улсын төмөр замын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг” хүргүүлсэн.<br>Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр зам байгуулах асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх, техникийн шийдэл гаргах, зөвшилцөх, хил дамнасан төмөр замыг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, гүйцэтгэлийг ажлын хэсэгт тайлагнах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулсан. | |
| 2 | Арга хэмжээ 1.1.2 Төмөр замын сүлжээг өргөтгөх төслүүдийг эрчимжүүлнэ.<br><br>*Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт* | *Эхний хагас жил:* Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗУС-д бүрэн шинжилгээг хийнэ.<br><br>Жилийн эцэс: Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулна. | I-IY | ЭЗХЯ-ны харьяа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ААТУТҮГ-т чиг үүргийн дагуу бүрэн шинжилгээ хийх төслийн багийг ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024.10.30-ны өдрийн А/264 дугаар “Төслийн баг байгуулах тухай” тушаалаар байгуулсан. ЗГ-ын 2023 оны 404 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-ын 4.7-т “Төслийн бүрэн шинжилгээг төслийн баг байгуулснаас хойш 6 сарын дотор хийж дуусгах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэг удаа 6 сар хүртэлх хугацаагаар сунгаж болно” гэж заасан байдаг. Бүрэн шинжилгээ хийж дуусгах хуулийн хугацаа 2025.04.30-нд дуусгавар болсон. Эссенз саплайз ХХК бүрэн шинжилгээ хийх хугацааг сунгах хүсэлтээ Түншлэлийн төвд хүргүүлсэн. Эссенз саплайз ХХК нь 2025.03.17-ны өдрийн №01 дугаартай албан бичгээр “Бүрэн шинжилгээний шатанд ТЭЗҮ боловсруулах зорилгоор ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж ирүүлэх хүсэлт” ирүүлснийг 2025.06.02-ны 08/2548 дугаартай албан бичгээр “Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөж, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг батлуулан” хавсралтаар хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-ын дагуу Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗУС-д урьдчилсан үнэлгээ хийж ирүүлэхийг 2025.06.27-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 01/101 дугаартай албан бичгээр мэдэгдэж, “МТЗ” ТӨХК 2025.07.28-ны өдрийн 01/1331 дугаартай албан бичгээр Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗУС-д | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | урьдчилсан үнэлгээ хийж ирүүлсэн. Зам, тээврийн яамны дэргэдэх Төмөр зам, далайн тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2025.09.04-ний өдрийн хурлаар Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-ийн төслийг хэлэлцэж, 2025.09.17-ны өдрийн 01/316 дугаартай албан бичгээр “Эссенз саплайз” ХХК-д санал зөвлөмжийг хүргүүлэв.<br>Төмөр замын тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн салбар дэд зөвлөлөөр 2025.09.04, 2025.11.12-нд 2 удаа хэлэлцүүлж, санал зөвлөмжийн дагуу ТЭЗҮ-д холбогдох сайжруулалт, нэмэлт өөрчлөлтийг тусгасны дагуу Зам, тээврийн яамны салбар зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлээд байна. | |
| | | Сайншанд-Баруун-Урт-Хөөт<br><br>*Эхний хагас жил:* Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн төмөр замын төслүүдийн ТЭЗҮ-д ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд урьдчилсан үнэлгээг хийж ЭЗХЯ-д хүргүүлнэ.<br><br>*Жилийн эцэс:* Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн төмөр замын төслүүдийн ТЭЗҮ-д ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд ЭЗХЯ, СЯ, аймаг, орон нутагтай хамтарч бүрэн шинжилгээг хийж. Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангана. | I-IY | Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамны зүгээс энэ төслийг буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлж БНСУ-ын хэд хэдэн байгууллагын төлөөллөөс бүрдсэн судалгааны баг боловсруулсан. Судалгааны багт БНСУ-ын Тээврийн Судалгааны Хүрээлэн (KOTI), Юшин Инженеринг компани (Yooshin Engineering), БНСУ-ын Үндэсний Төмөр Замын Корпораци (KORAIL), БНСУ-ын Гео шинжлэх ухаан, эрдэс баялгийн нөөцийн хүрээлэн (KIGAM) гэсэн талуудаас бүрдсэн консорциум ажилласан.<br>“Монголын төмөр зам” ТӨХК нь тус чиглэлийн төмөр замыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам” зэрэгт нийцүүлж хэрэгжүүлэх зорилгоор “Монголын төмөр зам” ТӨХК болон Японы Улсын “Ниппон коей” ХХК-уудын 2013 онд хамтран боловсруулсан “Монгол Улсын шинэ төмөр замын төслийн туслалцааны зөвлөх үйлчилгээ”-ний Зураг төслийн тайлан дахь техникийн үзүүлэлтэд тулгуурлан санхүүгийн тооцооллыг шинэчлэн боловсруулж урьдчилсан үнэлгээг боловсруулж 2025.09.30-нд албан бичгээр ЗТЯ-д ирүүлсэн. Тус урьдчилсан үнэлгээг хянаж, эдийн засгийн тооцоолол хэсгийг дахин сайжруулах чиглэлийг Төмөр замын газарт хүргүүлээд байна. | |
| | Улаанбаатар-Шинэ Хархорум ТХХТ | Сайншанд-Баруун-Урт-Хөөт<br><br>*Эхний хагас жил:* Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн төмөр | I-IY | “Монголын төмөр зам” ТӨХК болон “Солонгосын үндэсний төмөр зам” байгууллага хооронд 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, Улаанбаатар-Шинэ хархорум чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах чиглэлээр хамтран ажиллахаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | замын төслүүдийн ТЭЗҮ-д ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд урьдчилсан үнэлгээг хийж ЭЗХЯ-д хүргүүлнэ.<br><br>*Жилийн эцэс:* Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн төмөр замын төслүүдийн ТЭЗҮ-д ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд ЭЗХЯ, СЯ, аймаг, орон нутагтай хамтарч бүрэн шинжилгээг хийж. Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангана. | | тохиролцсон. БНСУ-ын Солонгосын үндэсний төмөр зам байгууллага нь дотооддоо тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулалтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд гүйцэтгэгчийг 2025 оны 04 дүгээр сарын 08-нд сонгон шалгаруулалт явуулж БНСУ-ын Сусонг инженеринг компани шалгарсан байна.Тус компанийн төлөөлөл 2025.05.22-нд ЗТЯ, МТЗ ТӨХК, Хархорин хотын захиргаатай хамтран ажиллах тухай уулзалт хийсэн. БНСУ-ын Сусонг инженеринг компани нь 240 хоногт тус чиглэлийн ТЭЗҮ-г боловсруулж, хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.<br>"Төслийн урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах БНСУ-ын Үндэсний төмөр замын байгууллагатай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр уулзалт хийж, судалгаа хийхэд шаардлагатай материалын жагсаалтыг баталсан. Төлөвлөгөөний дагуу дараах бичиг баримтыг 2025 оны 08 дугаар сарын 28-нд хүргүүлсэн.<br>1.Төмөр болон авто замын урт, дунд хугацааны бодлого, түүний төлөвлөгөө-12 хуудас<br>2. Монгол Улсын төмөр замын салбарын өнөөгийн байдал, төсөл хөтөлбөрийн танилцуулга- 15 хуудас<br>3. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө – 133 хуудас<br>4. Монгол Улсын авто замын өнөөгийн байдал, төсөл хөтөлбөрийн танилцуулга – 6 хуудас<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 8 асуултад хариулт болон асуумжийг 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлсэн. | |
| | Чойбалсан-Бичигт-Зүүнхатавч | *Эхний хагас жил:* Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр замын 2013 онд хийсэн ТЭЗҮ хянан дахин боловсруулна.<br>*Жилийн эцэс:* ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд ЭЗХЯ, СЯ, аймаг, орон нутагтай хамтарч ТЭЗҮ-д бүрэн шинжилгээг хийж. Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангана. | I-IY | “Монголын төмөр зам” ТӨХК нь тус чиглэлийн төмөр замыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам” зэрэгт нийцүүлж хэрэгжүүлэх зорилгоор “Монголын төмөр зам” ТӨХК болон Японы Улсын “Ниппон коей” ХХК-уудын 2013 онд хамтран боловсруулсан “Монгол Улсын шинэ төмөр замын төслийн туслалцааны зөвлөх үйлчилгээ”-ний Зураг төслийн тайлан дахь техникийн үзүүлэлтэд тулгуурлан санхүүгийн тооцооллыг шинэчлэн боловсруулж урьдчилсан үнэлгээг боловсруулж 2025.09.30-нд албан бичгээр ЗТЯ-д ирүүлсэн. Тус урьдчилсан үнэлгээг хянаж, эдийн засгийн тооцоолол хэсгийг дахин сайжруулах чиглэлийг Төмөр замын газарт хүргүүлээд байна. | |
| | Сүхбаатар-Хөшгийн хөндий-Замын-Үүд | *Эхний хагас жил:* | I-IY | Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын төмөр замын төв коридорыг | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Сүхбаатар-Хөшигийн хөндий-Замын-Үүд чиглэлийн төмөр замын 2007 онд хийсэн ТЭЗҮ-ийг хянан шинэчлэн боловсруулна.<br>*Жилийн эцэс:*<br>ОХУ, БНХАУ-ын талуудтай төмөр замын бүтээн байгуулалтын талаар яриа хэлэлцээ хийж, санхүүжилтийг шийдвэрлэнэ. | | шинэчлэн хөгжүүлэх техник-эдийн засгийн үндэслэлийг судлах хамтарсан ажлын хэсгийн гуравдугаар хуралдааны протоколоор гадаад худалдааны ачаа тээврийн тоо хэмжээний таамаглалыг 2025-2050 онуудаар, ТЭЗҮ боловсруулах нэгдсэн төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах Техникийн ерөнхий даалгаврыг тус тус протоколын хавсралтаар баталгаажуулсан. Мөн гурван тал протоколыг гарын үсэг зурж албажуулсан.<br>ОХУ-ын Тээврийн яамнаас Орос талын ТЭЗҮ-гийн хураангуй материалыг ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамаар уламжлуулан 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 2954 дугаар албан бичгээр тус яаманд ирүүлсэн.<br>Ажлын хэсгийн гуравдугаар хуралдааны протоколын дагуу 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Орос, Хятадын талуудтай шинжээчдийн түвшний уулзалтыг Монгол Улсын Улаанбаатар хотноо цахимаар зохион байгуулж техник-эдийн засгийн үндэслэлийг нэгтгэх асуудлаар санал солилцож тохирсон. Орос, Хятадын талаас Монголын талын ТЭЗҮ-гийн эцсийн хувилбарыг албан байдлаар ирүүлэхийг хүссэн бөгөөд Монголын тал ТЭЗҮ-г англи хэл дээр орчуулан ГХЯ-аар дамжуулан 2 талд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн шинжээч нарын хурлыг 2025.10.23-нд Улаанбаатар хотноо зохион байгуулж, энэ ондоо багтаан нэгтгэхээр тохиролцоод байна. | |
| 3 | Арга хэмжээ 1.3.3 Төмөр замын тээврийн үнэ тарифыг тооцох аргачлал боловсруулна. | *Эхний хагас жил:*<br>Төмөр замын тээврийн үнэ, тариф тооцох аргачлал боловсруулах судалгаа хийн аргачлал боловсруулан батлуулна. | I-II | Төмөр замын тээврийн тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлэх талаар судалгаа хийж дууссан бөгөөд Тавантолгой-Ханги чиглэлд 1тн нүүрсний авто тээврийн үнэ 101,266 төгрөг байна. Төмөр замын холимог тээврийн үнэ 118,080 төгрөг байна. Зам тээврийн сайдын шуурхай хурлаас өгөгдсөн үүргийн дагуу МТЗ ТӨХК -ийн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар 2,1 сая тонн-оос дээш ачаа тээвэрлэсэн тохиолдод суурь бүтэц ашиглалтын тарифыг 50 хувь хөнгөлсөнөөр төмөр замын тариф 97,609 төгрөг болж авто тээвэртэй өрсөлдөхүйц болж буурсан.<br>Тавантолгой-Гашуунсухайт-Ганцмод чиглэлд 1тн нүүрсний авто тээврийн үнэ 53,264 төгрөг, Төмөр замын холимог тээврийн үнэ 56,704 төгрөг байна. Зам, тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/183 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж суурь бүтэц ашиглалтын тарифыг 40 хувь бууруулснаар нэг тонн нүүрсийг 54,027 төгрөг болж буурахаар байна. Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 135 дугаар | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тогтоолоор "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын нөөцийг өсгөх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" тогтоолд ТНАЛТ-өөс хоногт 8-аас багагүй галт тэргэнд нүүрсний ачилт хийхийг үүрэг болгосон. ТНАЛТ-өөс ачилт хийсэн тохиолдолд 1 тн нүүрсийг 47,816 төгрөгөөр тээвэрлэлт хийх боломж бүрдэнэ. Зам тээврийн сайдын өгсөн үүргийн дагуу АТБЗГ-ын дарга Э.Мөнхнасангаар ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд Эрдэнэс тавантолгой уурхай, Гашуунсухайт боомтод ажиллаж дотоодын богиныг тээврийн тарифыг хэрхэн бууруулах талаар судалгаа хийж танилцуулсан. Одоогоор авто тээвэрлэгч нартай уулзалт зохион байгуулж хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд төмөр замын холимог тээврийн тариф 10 хувиар буурахаар тооцоолол хийсэн. Тавантолгой-Мандал чиглэлд төмөр замын тээврийн тариф 37 хувиар буурсан. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд төмөр замын тээврийн тариф 26 хувиар буурсан. Төмөр замын тээврийн үнэ тарифыг тооцох аргачлал боловсруулах ажлын хэсгийн Төмөр замын газрын даргын 2025.09.30-ны өдрийн А/51 дугаар тушаалаар баталсан. Ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 07-ний өдөр, 12 дугаар сарын 05-ны өдөр хуралдаж үүрэг даалгавар өгч ажилласан. БНХАУ, ОХУ-д мөрдөгдөж байгаа аргачлалыг орчуулж, судалсан. | |
| 4 | Арга хэмжээ 4.3 Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлнэ. | *Эхний хагас жил:* Сингапур, БНХАУ, Филиппин улстай нислэгийн багтаамжийг нэмэгдүүлнэ. *Жилийн эцэс: ХБНГУ-тай улстай нислэгийн давтамж нэмэгдүүлнэ.* | I-IY | <u>Сингапур:</u> Сингапуртай 2023 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгээр нислэгийн давтамж, багтаамжийг ямарваа нэгэн хязгаарлалтгүй болсон тул дахин хэлэлцээ хийх, шинэчлэх шаардлагагүй болсон. Нислэгийн давтамж, нислэгийн тоонд аливаа хязгаарлалт байхгүй.<br><u>БНХАУ:</u> БНХАУ-тай цэг нэмэгдүүлэх хүсэлтийг албан бичгээр болон цахимаар удаа дараа хүргүүлэн хэлэлцсэний үндсэн дээр Хятадын талаас 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн ноот бичгээр Харбин хотыг Эрээн хотоор солих манай талын хүсэлтийг хүлээн авснаа нотолсон. Монголын талаас Эрээн чиглэлд томилогдсон "МИАТ" ТӨХК, "Хүннү Эйр" ХХК-д нислэгийн зөвшөөрөл олгуулах хүсэлтийг ГХЯ-аар дамжуулан хятадын талд хүргүүлсэн. /2025.09.29-ний 02/4406 тоот албан бичиг/ Үүний үр дүнд одоогоор Хүннү Эйр ХХК Эрээн чиглэлд 7 хоногт 7 удаа нислэг үйлдэж байна. "МИАТ" ТӨХК 2026 оноос тухайн чиглэлийн нислэгээ эхлүүлнэ.<br><u>Филиппин:</u> Филиппин Улстай нислэгийн давтамж маршрутын хуваарийг | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | шинэчлэх, аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт тохирох хүсэлтийг албан бичгээр айлын талд хүргүүлсэн. Энэхүү тохиролцооны харилцан ойлголцлын санамж бичгийг Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн хурал (ICAN 2025)-ын үеэр байгуулахаар төлөвлөсөн хэдий ч хоёр тал тус хуралд оролцох боломжгүй болсон. Айлын талаас давтамж нэмэгдүүлэх талаарх хэлэлцээг 2026 оны 1 дүгээр улиралд хийх саналтай байгаа талаар хариу ирүүлсэн./2025.10.01-ний 25/554 тоот/ Иймд Филиппинтэй нислэгийн давтамж нэмэгдүүлэх ажил айлын талаас шалтгаалан хүлээгдэж байна.<br>ХБНГУ: ХБНГУ-тай байгуулсан хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг, санамж бичгийн төслийн хамт цахимаар удаа дараа хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй болно. Германтай байгуулсан хэлэлцээрт өөрчлөлт оруулах асуудал айлын талаас шалтгаалан хүлээгдэж байна. | |
| 5 | Арга хэмжээ 5.1.3 Хуурай боомт байгуулах судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулна. | *Эхний хагас жил:* Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах хөрөнгийг шийдвэрлэж, төслийг эхлүүлнэ.<br><br>Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах нөхцөл байдлын үнэлгээ, судалгааны ажлыг эхлүүлнэ.<br><br>*Жилийн эцэс:* Замын-Үүд суманд хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төслийг ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.<br><br>Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа боловсруулж, шийдвэр гаргах түвшинд танилцуулна. | I-IY | 1. Дэлхийн банкны төлөөлөл болон яамны удирдлагууд 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр уулзсан уулзалтаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах хөрөнгийг Дэлхийн банкнаас шийдвэрлүүлэхээр тохирсон. Уулзалтын мөрөөр 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр болон 02 дугаар сарын 12-ны өдөр тус тус уулзан хөрөнгийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэн ЗТЯ-тай хамтран хэрэгжүүлж буй МУ-ын тээврийн сүлжээ, ложистикийг сайжруулах төслийн зээлийн санхүүжилтийн хамрах хүрээнд оруулан шийдвэрлэхээр тохирсон. Тус төслийн хүрээнд Олон улсын болон, дотоодын зөвлөх авах шатанд Дэлхийн банктай хамтран ажиллаж байна.<br>2. Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах судалгааны ажлыг хийх хөрөнгийг шийдвэрлүүлэх хүсэлтийг АХБ-ны төлөөллүүд ЗТЯ-ны ТНБД-тай 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хийсэн уулзалтын үед тавьж, Хөшигийн хөндийн дүр зургийн талаар танилцуулга бэлтгэн танилцуулсан. АХБ-ны зүгээс төвдөө танилцуулан шийдвэрээ эргэн мэдэгдэхээр тохирсон. 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Далайн захиргааны дарга Б.Сайнбаяр болон бусад холбогдох байгууллагын төлөөлөгчид НЗД-ын нэгдүгээр орлогч Т.Даваадалай болон Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | үүргийг хэрэгжүүлэх хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр нартай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Төв аймгийн Хөшигийн хөндий дэх “Чингис хаан олон улсын нисэх буудал”-ыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах газрын байршлын талаар санал солилцсон бөгөөд Далайн захиргааны зүгээс төмөр зам, дэд бүтэц болон логистикийн төвтэй ойрхон байршилд хуурай боомтыг байгуулах саналтай байгаагаа илэрхийлэв. ЗТЯ, Дэлхийн банк хамтран хэрэгжүүлж буй Монгол Улсын тээврийн сүлжээ, ложистикийг сайжруулах төслийн зээлийн санхүүжилтийн хамрах хүрээнд Хяналтын зөвлөх авах ажлын сонгон шалгаруулалт хийгдэн шалгарсан байгууллагатай гэрээний хэлцэл хийгдэж байна. Тус гэрээнд “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах Зөвлөх үйлчилгээ авах ажлыг багтааж оруулсан болно.<br><br>Монгол улсын Далайн захиргаа Төв аймгийн Хөшигийн Хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах олон талт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн суурь судалгааг хийн боловсруулсан. Мөн 2025 оны ГХЯ-руу 03/5423 тоот албан бичгээр НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг, Нийгмийн комиссоос Гадаад харилцааны яамтай хамтран 2022 онд боловсруулсан "Хуурай боомтыг хөгжүүлэх зөвлөмж”-ийн холбогдох мэдээллийг авахаар бичиг хүргүүлсэн. | |
| 6 | Арга хэмжээ 8.1 Салбарын хуулиудыг шинээр болон шинэчлэн боловсруулна. | *Эхний хагас жил:*<br><br>Тээврийн ерөнхий хууль, Авто тээврийн тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудитын тогтолцоог бүрдүүлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан төслийг Засгийн газрын | I-IY | ТЗДТБЗГ: 2025.01.01-ний өдрөөс Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэн. Хууль хэрэгжих асуудлын хүрээнд дүрэм журмуудыг шинэчилэн боловсруулсан. ЗГ-ын 2025.02.05-ны өдрийн 73 дугаар тогтоолоор “Төмөр замын газар байгуулахаар тогтоосон. Төмөр замын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан.<br>Уг тогтоолоор санхүү хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>БТГ: Авто тээврийн тухай хуулийн төслийг боловсруулан зөвлөх үйлчилгээ авахаар Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг батлуулаад байна.<br>Тээврийн ерөнхий хуулийн төслийг боловсронгуй болгох ажлын хүрээнд | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хуралдаанаар хэлэлцүүлнэ. *Жилийн эцэс:* Хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлнэ. | | 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр ажлын хэсэг шинэчлэн батлагдаж, удирдамжийн дагуу Олон Улсад жишиг болон хэрэгжиж буй бусад улс орны Тээврийн ерөнхий хууль, ижил төстэй хуулиудыг судлан танилцуулах ажлыг гүйцэтгээд байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тул шинэчлэн байгуулах төслийг танилцуулж байна.<br>ТЗУГ: Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Төмөр замын агентлаг байгуулах УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулж батлуулсан. Уг тогтоолын төслийг УИХ- ын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br>Автотээврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулахад хамтран ажилласан.<br>Мөн "Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна.<br>АТБЗГ: Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Автотээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээний тайланг боловсруулсан. Уг үнэлгээний тайлангийн дүгнэлтэд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан ХЗДХСайдтай хамтран батлахаар албан бичгийн төслийг боловсруулан санал авсан бөгөөд сайдын зөвлөхөөс Тээврийн ерөнхий хуулийн төсөлтэй хамтатган боловсруулах чиглэлийг өгсөний дагуу Тээврийн ерөнхий хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцүүлэхээр хүлээгдэж байна.<br>- Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаагаар хэрэгжиж байгаа "TA-6591 REG: Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөрийн Гишүүн Орнуудын "Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлыг Сайжруулах Төсөл"-ийн хүрээнд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудитор, iRAP буюу Олон улсын авто замын үнэлгээний хөтөлбөр"-ийн талаар мэдлэг олгох сургалтыг 2025 оны 09 сарын 08-19-ний өдрүүдэд нийт 70 хүнийг хамруулан зохион байгуулснаас 54 хүн шалгалтанд тэнцэж, амжилттай төгссөн. Төслийн багаас боловсруулсан аудитын тогтолцоог бүрдүүлэх журмын төслийг хүлээн авсан.<br>Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 5 гишүүний | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | санаачилсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” хуулийн төсөлтэй танилцаж, холбогдох саналыг боловсруулан, Зам, тээврийн сайдын 2025 оны 01/2502 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгтэй хамтран 2025 оны 05 сарын 26-ны өдөр Төрийн ордонд хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл хийж, санал өгөв.<br>Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэгт орж, Зам, тээврийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/5866 дугаартай албан бичгээр хуулийн төсөлд санал өгч, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.<br>СХГ: Салбарын хяналтын газрын дарга Тээврийн ерөнхий хуулийн ажлын хэсэгт орж ажиллаж байна.<br>Ажлын хэсгийн хурал 2 удаа хуралдсан. Холбогдох тандалт судалгааны ажил хийсэн. Үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан. Үр нөлөөллийн судалгааг ЗТХТ-д хүргүүлж, хөндлөнгийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.<br>ТЗУГ: Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Төмөр замын агентлаг байгуулах УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулж батлуулсан. Уг тогтоолын төслийг УИХ- ын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br>Автотээврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулахад хамтран ажилласан.<br>Мөн “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна. | |
| *“70” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ* | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.2.3 Төмөр замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулна. | *Эхний хагас жил:* “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн төмөр замын суурь бүтцийн их засварын ажлыг эхлүүлнэ. | I-IY | Ерөнхий хорооны хурлаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж төлөвлөгөөнд 80 км их засварын ажил тусгагдсан.<br>2025 оны 6 сарын байдлаар 18 км гол замд их засварыг хийсэн. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *Жилийн эцэс:* Гол замын 80 км төмөр замд их засвар хийнэ. Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр зам Төмөр замын өргөтгөл шинэчлэлийг бүрэн дуусгана. Сайншанд, Зүүнбаян өртөөдийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг эхлүүлнэ. | | УБТЗ” ХНН-ийн 2025 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөнд туссан Олон-Овоо-Цомог-Айраг болон Багахангай өртөө хоорондын гол замд зам шинэчлэлтийн их засварыг 2025.05.12-ны өдрөөс 2025.08.26-ны өдрийн хооронд 31 удаагийн цонхны ажилд 34656.9 пог.м замын их засварыг хийж дуусгасан. Биелэлт-101.9% | |
| 2 | Арга хэмжээ 1.2.5 Төмөр замын тээврийн асуудал хариуцсан сайд нарын түвшний гурван талын уулзалт зохион байгуулна. | *Эхний хагас жил:* Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын төмөр 1 замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх асуудлаар төмөр замын тээврийн асуудал хариуцсан сайд нарын түвшний гурван талын уулзалт зохион байгуулна. | I-II | Гурван улсын Тээврийн сайд нарын уулзалт зохион байгуулах саналыг ОХУ-ын тээврийн дэд сайдтай 2025.02.10-ны өдөр хийсэн уулзалтын үеэр, Хятадын талд 2025.03.07-ны өдрийн 03/985 дугаар албан бичгээр ГХЯ-аар уламжлуулж тус тус хүргүүлж уулзалтын бэлтгэл хангасан.<br>2025 оны 06-р сарын 30-наас 07-р сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ШХАБ-ын Тээврийн сайд нарын 12-р уулзалтын үеэр зохион байгуулахаар тохирсон боловч Хятадын талын саналаар хойшлуулсан. | 70 |
| 3 | Арга хэмжээ 1.3.2 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлнэ. | Эхний хагас жил: Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг 5ш гол замын зүтгүүр, 100ш ачааны вагон, 1ш зорчигчийн вагоноор нэмэгдүүлнэ. Жилийн эцэс: Шинээр төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг 5 ш гол замын зүтгүүр, 3 ш сэлгээний зүтгүүр, 200 ш ачааны вагон, 1 ш зорчигчийн вагоноор нэмэгдүүлнэ. | I-IY | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “МАК Цемент” ХХК-ийн ЕС-75 загварын 20 ширхэг хагас вагон, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/44 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Монголиан транс ложистик” ХХК-ийн ЕС70С загварын 40 ширхэг хагас вагоныг тус тус хүлээж авсан. ТЗДТБЗГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 05/25 дугаартай удирдамжаар “Бас говь” групп ХХК-ийн 50 ширхэг хагас вагоныг хүлээж авсан. ТЗДТБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 08/25 дугаартай удирдамжаар “Ворлд энтри транспорс” ХХК-ийн 100 ширхэг хагас вагоныг хүлээж авсан. 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 210 ширхэг вагоноор парк нэмэгдсэн. Төмөр замын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/09, 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/30, 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Монложистик экуйпментс” ХХК-ийн ачааны 40 хагас вагон, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 1 илчит тэрэг, “Бодь рэйл” ХХК-ийн ачааны 100 хагас вагоныг хүлээж авсан. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ТЗГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны А/58 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж “Прайм роу ложистик” ХХК-ийн 50 ширхэг хагас вагоныг Замын-Үүд өртөөнд хүлээж авсан. ТЗГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/62 тоот тушаалаар “Ворлд энтри транспортс” ХХК-ийн 100 ширхэг хагас вагоныг Сүхбаатар өртөөнд хүлээж авсан. ТЗГ-ын даргын А/63 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж “Прайм роу ложистик” ХХК-ийн 50 ширхэг хагас вагоныг Замын-Үүд өртөөнд хүлээж авсан. ТЗГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/70 тоот тушаалын дагуу “Дабль лакки” ХХК-ийн 50 ширхэг хагас вагоныг Сүхбаатар өртөөнд хүлээж авсан. ТЗГ-ын даргын А/72 тоот тушаалын дагуу “Бас говь” ХХК-ийн 50 ширхэг хагас вагоныг Сүхбаатар өртөөнд хүлээж авсан. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар гол замын зүтгүүр 3 ш нэмэгдсэн, УБТЗ-2 ш зүтгүүр энэ онд багтаан авна.Нийт 12245 ширхэг хөдлөх бүрэлдэхүүнтэй. Үүнээс Зүтгүүр 212 ш, Ачааны вагон 11698 ш, Зорчигчийн вагон 335 ш байна. | |
| 4 | Арга хэмжээ 2.2.3 Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID) нэвтрүүлэх хүрээнд авто замаас төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулах төслийг хэрэгжүүлнэ. | Эхний хагас жил: Төлбөр авах 25 цэгийг цахимжуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлнэ.<br>Жилийн эцэс: Төлбөр авах цэгийг бүрэн цахимжуулна. | I-IY | Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хяналт бүртгэлийн систем ЗТЯ/20250101046 дугаар тендерт Инфокон ХХК шалгарч (50 сая төгрөг) гэрээ байгуулсан.<br>Олон улс, улсын чанартай авто замд RFID технологид хяналт тавих тоног төхөөрөмж суурилуулах" ЗТЯ/20250101049 дугаар тендерт Арш технологи ХХК шалгарч (2,683,088,293 төгрөг ) гэрээ байгуулсан.<br>Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдээр дамжуулан техникийн хяналтын үзлэгт хамрагдаж буй тээврийн хэрэгсэлд RFID tag наах ажлыг хэрэгжүүлж байгаа ба 2025.11.30-ний өдрийн байдлаар 471,083 тээврийн хэрэгсэлд суурилуулаад байна. Төлбөр хураах 37 цэгээс 12 цэг нь бүрэн цахимжсан байна. 25 цэгийг цахимжуулахаар шалгарсан байгууллагатай 2.3 тэрбум төгрөгийн гэрээг “Арш технологи” ХХК-тай 2025.12.03-ны өдөр байгуулан, бэлтгэл ажлыг ханган ажиллав. | 70 |
| 5 | Арга хэмжээ 3.3.2 Олон улсын болон улсын үндэсний авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлнэ. | Эхний хагас жил: Төсвийн жил дамжин хэрэгжиж буй болон 2025 онд шинээр хэрэгжих бүх төслийн барилгын ажлуудыг эхлүүлнэ.<br>Жилийн эцэс: 1245.61км авто зам, 274.45 | I-IY | 2025 онд хөрөнгө нь бүрэн тусгагдаж, гэрээний хугацаа дуусаж буй төсөл хөтөлбөрүүдийн барилгын ажлыг батлагдсан график төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | урт/метр гүүр байнгын ашиглалтад оруулж олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын уртын эзлэх хувь 57.7 хувьд хүргэнэ. | | | |
| 6 | Арга хэмжээ 4.1 Олон улсын агаарын тээврийн харилцааг өргөжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ. | Эхний хагас жил: Кувейт, Австрали, Итали, Иран Улсуудтай шинээр агаарын харилцааны хэлэлцээр байгуулна. Жилийн эцэс: Испани, Нидерланд, Азербайжан, Словени, Саудын Араб, Руанда, Улсуудтай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулна. | I-IY | <u>Кувейт:</u> "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Эль-Кувейт хотноо 2025.01.19-ний өдөр байгуулсан. "Хэлэлцээр батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2025.02.19-ний өдрийн 01/788 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хэлэлцээрийг Засгийн газрын 2025.03.06-ны өдрийн "Хэлэлцээр батлах тухай" 118 дугаар тогтоолоор баталсан.<br><u>Австрали:</u> Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Австралийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 01/3549 дугаартай албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авсан. Улмаар хэлэлцээрийн төсөлд саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 01/4074 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.<br><u>Итали:</u> "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Ром хотноо 2025.01.23-ны өдөр байгуулсан. "Хэлэлцээр батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2025.02.19-ний өдрийн 01/789 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хэлэлцээрийг Засгийн газрын 2025.03.06-ны өдрийн "Хэлэлцээр батлах тухай" 117 дугаар тогтоолоор баталсан.<br><u>Иран:</u> "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Иран Улсын Засгийн газар | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хоорондын хэлэлцээр"-ийн төслийг эцэслэн тохиролцсон. Ираны агаарын тээвэрлэгчид АНУ-ын хориг орсонтой холбогдуулан агаарын харилцааны хэлэлцээр байгуулах асуудлаар чиглэл авахаар ГХЯ-нд албан бичиг хүргүүлсэн. Гадаад харилцааны яамнаас өгсөн чиглэлийн дагуу Иран Улстай хэлэлцээр байгуулах асуудал тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.<br><u>Болгар:</u> Бүгд Найрамдах Болгар Улсын Иргэний нисэхийн удирдах газартай 2025 оны 03 дугаар сард цахимаар хэлэлцээ хийж, "Агаарын харилцааны тухай" хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, үзэглэсэн. "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төсөлд Зам, тээврийн сайдын 2025.04.25-ны өдрийн 01/1922 дугаар албан бичгээр яамдаас санал санал авч, 2025.05.23-ны өдрийн 01/2402 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. Хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай ЕС-ын захирамжийг Элчин сайд Л.Саянаад олгуулах хүсэлтийг 2025.11.07-ны өдрийн 01/5159 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2025.11.14-ний өдрийн 138 дугаар захирамжаар хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Элчин сайд Л.Саянаад олгосон. Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэх үеэр 2025.11.21-ний өдөр Софи хотноо хэлэлцээрийг байгуулсан.<br><u>Испани:</u> "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Испанийн Хаант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг орчуулж, холбогдох танилцуулгыг бэлтгэсэн. Хэлэлцээрийн төсөлд яамдаас санал авах шатанд байна. Энэ 12 дугаар сард багтаан хэлэлцээрийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><u>Нидерланд</u>: "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Нидерландын Хаант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төсөлд Зам, тээврийн сайдын 2025.04.25-ны өдрийн 01/1922 дугаар албан бичгээр санал авч, 2025.05.23-ны өдрийн 01/2402 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, хэлэлцээрт гарын үсэг зурах Ерөнхий сайдын захирамжийг ажлын шугамаар гаргахаар тогтсон. Хэлэлцээрийг хоёр талын өндөр дээд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хэмжээний айлчлалын үеэр байгуулахаар хүлээгдэж байна.<br>Саудын Араб: “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Саудын Арабын Хаант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Улаанбаатар хотноо 2025 оны 07 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан. Хэлэлцээрийг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.<br>Руанда: “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Руанда Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг орчуулж, холбогдох танилцуулгыг бэлтгэн яамдаас санал авахаар 2025.11.27-ний өдрийн 01/5488 тоот албан бичгээр хүргүүлсэн. Яамдын саналын нэгтгэж, хэлэлцээрийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. Энэ 12 дугаар сард багтааж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. | |
| 7 | Арга хэмжээ 4.6 Орон нутгийн нисэх буудлуудыг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг эрчимжүүлнэ. | Эхний хагас жил:<br><br>Жилийн эцэс: | I-IY | Тайлбар: “Дэлүүн болдог” нисэх буудлын ЗҮБ, байгууламж “Өндөрхаан” нисэх буудлын төсөл, “Гурвансайхан”, “Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд багц ажлын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 70 хувийн хэрэгжилттэй бөгөөд “Гурвансайхан”, “Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан” нисэх буудлын ажлын хэрэгжилт 30 хувийн үнэлгээтэй тул багцалж төлөвлөсөн хэрэгжилт хангалтгүй ажлуудын жагсаалтад оруулав. | 70 |
| 8 | Арга хэмжээ 4.9 Олон улсын нисэх буудлыг өргөтгөх, ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна. | Эхний хагас жил: "Чингис хаан" нисэх буудлын өргөтгөл хийх ТЭЗҮҮС боловсруулах санхүүжилтийг эрэлхийлж, зөвлөхийг сонгон шалгаруулна.<br>“Шинэ Хархорум” нисэх буудал байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулна.<br>Жилийн эцэс: ТЭЗҮУС, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ. | I-IY | • “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын өргөтгөлийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Ориентал Консалтантс Глобал” ХК шалгарч, 2025 оны 05 дугаар сараас ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Судалгааны баг 2025.08.13-нд эрэлтийн таамаглал, 10 дугаар сарын 21-нд төсөвт өртөг, 11 сарын 24-нд явцын тайлангийн талаар тус тус мэдээлэл хийсэн. Төслийн эцсийн тайлан 2026.05 сард бэлэн болох хуваарьтай байна.<br>Шинэ хархорум - Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтыг үндэслэн Хот, байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Хархорум хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын зураг төсөл боловсруулах ажлын хөрөнгө өртөг болох 3.197 тэрбум төгрөгийг шийдвэрлэхээр тусгасан. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | "Шинэ Хархорум" хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл боловсруулах 3,197,500,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий тендер шалгаруулалтыг 2025.04.15-ны өдөр болон 2025.06.27-ны өдрүүдэд зарласан боловч тендерт шалгарагч тодроогүй. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсанаар холбогдох гэрээ хийгдээгүй бүх төсөл хөтөлбөрүүдийг царцаасан тул санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна. Тус яамнаас Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-д нийцүүлэн төслийн дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэгжилтийн үе шат, график, холбогдох тооцоо, судалгааг ИНҮТ ТӨХХК болон Хархорум хотын захиргаатай хамтран боловсруулан ирүүлэхийг ИНЕГ, “ИНҮТ” ТӨХХК-д үүрэг болгоод байна. (2025.08.11 09/3617) | |
| 9 | Арга хэмжээ 9.1 Зам, тээврийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | Эхний хагас жил: Төлөвлөгөөний төслийг батлуулна. | I-II | Зам, тээврийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг газруудаас санал авч тусган, боловсруулсан. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /5 сард/ албажин Legalinfo-д байршсантай холбогдуулан уг төлөвлөгөөтэй нийцүүлж, нэмэлт өөрчлөлт оруулах, Зам, тээврийн яамны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр ЗГ-ын 2025 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан тул уг хөтөлбөрт нийцүүлэх ажлууд хийгдээд байгаа бөгөөд МУ-ын 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг УИХ хэлэлцэн батлахтай холбогдуулан уг дунд хугацааны бодлоготой нийцүүлэн батлуулахаар ажиллаж байна. | 70 |
| 10 | Арга хэмжээ 10.5 Төрийн албаны зөвлөлийн салбар үйл ажиллагаа зохион байгуулна. | Эхний хагас жил: Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв олгох асуудлыг шийдвэрлэнэ.<br><br>Жилийн эцэс: Хүний нөөцийг тухай бүр бүрдүүлж, холбоотой бусад асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн байна.<br><br>Жилийн турш: “Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн | I-IY | Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/4467 дугаар албан бичгээр хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 419, 421, 423 дугаар тогтоолоор салбар зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг шинээр томилсон. Төслийн нэгжүүдийн сул орон тоог нөхөх ажлын байрны зарыг Зам, тээврийн яамны (www.mrt.gov.mn) цахим хуудсанд байршуулан, материалуудыг хүлээн авч байна.<br>2025 онд Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль шинээр хэрэгжиж эхлэсэнтэй холбогдуулан Зам, тээврийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг боловсуулж, Засгийн газрын гишүүдээс санал авч боловсруулан Засгийн | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт"-ийг яамны цахим хуудсанд байршуулж, ил тод байдлыг хангана.<br>Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулж, салбар зөвлөлийн хуралдааныг хуралдуулж зөвлөлийг 10 удаа хуралдуулж, хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | | газрын 2025 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. Тус яамны бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/106 дугаар тушаалаар "Ажлын байрны жагсаалт, орон тоо"-г шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/236 дугаар тушаалаар байгуулан ажиллаж Төрийн албаны зөвлөлд Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлах зөвшөөрөл авахаар 2025 оны 02/4903 албан тоот бичгээр хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 490, 491, 492, 493 дугаар тогтоолоор тус яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах зөвшөөрлийг олгосон. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/152-Б/160 дугаар тушаалаар тус тус яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан.<br>ЗГХЭГ-ын 2025 оны ХЭГ/1760 дугаар албан бичгээр ажлын байранд сонгон шалгаруулалт зарлахгүй байхаар чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг ирүүлсэн. | |
| 11 | Арга хэмжээ 11.7 Хяналт-шинжилгээ, үнэлгээний программыг шинэчлэн, яамны үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. | Эхний хагас жил:<br>I улирал:<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний программын ажлын даалгаврыг боловсруулна.<br>II улирал:<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний программын ажлын даалгаврыг батлуулна.<br>Жилийн эцэс: III улирал:<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний программын туршилтыг хийнэ.<br>IV улирал:<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний программыг шинэчлэн, сайжруулж үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. | I-IY | Яам, харьяа агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын давхардал, тайлагналын процессын хүндрэлүүдийг илрүүлж, шинэчлэх шаардлагатай функцүүдийг тодорхойлсон.<br>Энэ ажлын хүрээнд тус яамны Мэдээллийн технологийн хэлтэс, "Эйбл софт" ХХК-тай хамтран "Able" системд "Гүйцэтгэлийн төлөвлөгөө", "Хяналт-шинжилгээ, үнэлгээ" гэсэн цэсийг шинэ эр нэмж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийг цахим системд оруулах туршилтын орчныг нээсэн.<br>Тус яамны бүтцийн нэгжүүдийг хамруулан 2 удаагийн туршилт хийж алдаа, засвар шинэчлэлтийн жагсаалтыг гарган "Эйбл софт" ХХК-д хүргүүлэн тус компанийн программ хангамжийн ажилтнуудтай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, санал солилцсон.<br>Цаашид программ хангамжийн хөгжүүлэлтийн гэрээ байгуулах, өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэх, хяналт-шинжилгээний бодит цагийн дашбоард үүсгэх зэрэг ажлуудыг удирдлагын түвшинд шийдвэрлүүлэх шаардлагатай байна. | 70 |
| 12 | Арга хэмжээ 12.4 Зам, тээврийн салбарын дэд | Эхний хагас жил: | I-IY | Төмөр замын чиглэлээр:<br>"УБТЗ" ХНН-ийн суурь бүтцийн гол замын техникийн байдал, замын засвар | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бүтцийн засвар үйлчилгээ, техник технологийн хяналт, аюулгүй ажиллагааг судалж, аюулгүй байдлыг хангуулна. | Салбарын хэмжээнд 3 судалгаа хийнэ.<br><br>Жилийн эцэс: Зам, тээврийн салбарын судалгааг үндэслэж аюулгүй байдлыг 30-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | | арчлалтад ашиглагдаж буй хүн хүч, машин механизм, авто замтай огтлолцсон төмөр замын гармуудын тоо, эрсдэлийн үнэлгээ зэргийг судалж, дүгнэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж СХГ-ын даргад танилцуулсан. Газрын даргаас цаашид судалгааг илүү нарийвчилж гаргах үүрэг даалгавар өгсний дагуу шинэчилж байна.<br>• Хөдлөх бүрэлдэхүүний насжилтын судалгааг 2025 оны байдлаар гаргасан. /Зорчигчийн вагоны 79%, зүтгүүрийн 34%, машин механизмын 69 % насжилтын хугацаа дууссан/<br>• Зам тээврийн сайдын 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/160 тушаалын биелэлтийг судалгаа хийж гаргаж танилцуулсан. Түрээсийн ачааны вагон 2024 оны 9 сарын байдлаар 1472 байсныг дунд засварт орох хүртэл хугацаанд ашигласан ба 2025 оны 6 дугаар сарын байдлаар 632 вагон үлдсэн байна.<br>• Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан танилцуулсан.<br>• “УБТЗ” ХНН-ийн ашиглалтын хугацаа дууссан 1048 вагоныг актлан зам багтаамжийн хэтрэлтийг арилган эрсдэлийг бууруулж, шинэ вагон худалдан авахад шаардлагатай зам багтаамжийн хүрэлцээ нь хангагдахаар байна гэдэг саналыг танилцуулсан болно.<br>Авто замын чиглэлээр:<br>• Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, тухайн чиглэлийн авто замд техник ашиглалтын түвшин тогтоосон эсэх, зурвас газрын судалгаа, кадастр хийгдсэн эсэх, улсын төсвөөс засвар, арчлалтын ажилд тавигдсан хөрөнгө болон нэмэлт хөрөнгийн мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар гаргаж, судалгаа хийсэн. (“ЗТХТ” ТӨҮГ, “АЗЗАН” ТӨХК-д 2025.03.18-ны өдрийн 11/1180, 11/1181 тоот албан бичгээр хүргүүлж, 2025.03.27-ны өдрийн 1/269 дугаартай албан бичгээр 416 гүүр, 40 чиглэлийн авто зам болон 62025156 дугаартай албан бичгээр 102 гүүр, 27 чиглэлийн авто замын мэдээлэл хүлээн авсан).<br>• Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд тухайн аймгийн улсын чанартай авто замын ашиглалтын байдлыг үзлэг шалгалтыг газар дээр нь хийж, илэрсэн дутагдлыг арилгуулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар улсын ахлах байцаагчийн 14 албан шаардлагыг захиалагч, зөвлөх, хариуцагч байгууллагуудад хүргүүлж ажилласан. Судалгааг 2025 онд хийсэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хяналт шалгалтын тайлантай уялдуулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах үүднээс насжилт ихтэй авто замын их хэмжээний эвдрэлтэй хэсэгт техник ашиглалтын түвшин шинэчлэн тогтоох, туршилт шинжилгээний үндсэн дээр хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн даацад тохирсон засварын аргачлал боловсруулж, холбогдох норм дүрэм, техникийн шаардлага, стандартын дагуу засвар, шинэчлэлтийн ажлыг шат дараалалтайгаар хийх, эвдрэлийн хэмжээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан. Саналыг үндэслэн “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т зөвлөмж хүргүүлсэн.<br>• Авто зам, замын байгууламжийн барилгын ажил болон засвар арчлалтын ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ААНБ-д хийсэн хяналт шалгалтын үр дүнг үндэслэн техник, технологийн хяналтын үйл ажиллагааны нөхцөл байдал, нийтлэг гаргадаг алдаа дутагдалд судалгаа хийж, дүгнэлтэд үндэслэн 17 хяналт хэрэгжүүлэгч ААНБ-д улсын байцаагчийн 2025.03.17-ны өдрийн 04-00-02/007/12 дугаартай зөвлөмж болон илэрсэн дутагдлыг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 4 албан шаардлагыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>• Судалгааг 2025 онд хийсэн хяналт шалгалтын тайлантай уялдуулж, улсын төсөв, нийслэл, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээний үндсэн дээр хэрэгжиж буй авто зам, замын байгууламжийн барилга, өргөтгөл шинэчлэлт, их засварын ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулах, үүсэх эрсдэл, үр дагавараас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, Авто замын тухай болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор техник, технологийн хяналтыг сайжруулах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ болон Зөвлөх байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.<br>Автотээврийн чиглэлээр:<br>• Нийтийн зорчигч тээврийн осол, зөрчлийн мэдээллийг гаргуулан авахаар СХГ-ын даргын 2025.02.17-ны өдрийн 11/746 тоот албан бичгийг Нийтийн тээврийн бодлогын газар, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-т | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу Нийтийн тээврийн бодлогын газраас эхний ээлжид сүүлийн 5 жилийн хугацаанд гарсан осол, зөрчлийн мэдээллийг гаргуулан авч судалгаа хийсэн.<br>• Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 13 аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн 63 автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал нь стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 84 зөрчлийг илрүүлж, улсын ахлах байцаагчийн 10 акт, 7 албан шаардлагыг хүргүүлэв. Зөрчил гаргасан 3 аж ахуйн нэгж, байгууллагад /дөрвөн сая./ төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, барагдуулав.<br>• Шалгалтын дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний саналыг Автотээврийн бодлого зохицуулалтын газарт 2025.02.24 06 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуй нэгж, байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо, ямар үзүүлэлтээр тэнцээгүй талаарх дэлгэрэнгүй тайланг тус газарт ирүүлэх талаар СХГ-ын даргын 2025.04.25-ны өдрийн 11/1887 тоот албан бичгийг хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу 16 аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн тайланг үндэслэн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо, тэнцээгүй үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийсэн.<br>Орон нутгийн замд гарч байгаа зам тээврийн ослын дийлэнх нь хурд хэтрүүлснээс үүдэлтэй ослын тоо их байгааг бууруулах чиглэлээр хурдны хяналт, жолоочийн ажил амралтын дэглэмийг хянахтай холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2025 онд нийт 115.951 зөрчил бүртгэгдэж, 950 осол гарсан байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15%-иар буурсан үзүүлэлттэй байна. | |

## 2.4.Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын 8 хуулийн 47 заалт, Улсын Их Хурлын 20 тогтоолын 43 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 10 тогтоолын 24 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт, Засгийн газрын 116 тогтоолын 178 заалт, Засгийн газрын хуралдааны 99 тэмдэглэлийн 203 заалт, Засгийн газрын 7 албан даалгаврын 80 заалт, Ерөнхий сайдын 5 захирамжийн 5 заалт, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмжийн 1 заалт буюу нийт 269 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 585 заалтыг 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авч,

хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дундаж үнэлгээ 89 хувьтай байгаа бөгөөд үнэлгээг Хүснэгт №8-д харуулав.

*Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ*

*Хүснэгт №8*

| | | Нийт | МУ-ын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ЗГ-ын тогтоол | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | ЗГ-ын албан даалгавар | Ерөнхий сайдын захирамж | УАБЗ-ийн зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | 269 | 8 | 20 | 10 | 3 | 116 | 99 | 7 | 5 | 1 |
| Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо | | 585 | 47 | 43 | 24 | 4 | 178 | 203 | 80 | 5 | 1 |
| Хэрэгжсэн | Хэрэгжсэн - 100% | 427 | 19 | 32 | 23 | 4 | 140 | 160 | 44 | 4 | 1 |
| | Ахиц гарсан - 50% | 45 | 19 | 4 | 1 | - | 8 | 12 | 1 | - | - |
| | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | 4 | - | - | - | - | 4 | - | - | - | - |
| | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | 57 | 7 | 1 | - | - | 6 | 16 | 27 | - | - |
| Хэрэгжээгүй | Зохион байгуулалтаас - 0% | 5 | 1 | - | - | - | 1 | 2 | - | 1 | - |
| | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | 2 | - | - | - | - | 2 | - | - | - | - |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | Х.Б | 35 | - | 4 | - | - | 13 | 11 | 7 | - | - |
| Хэрэгжих боломжгүй | Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | 2 | 1 | 1 | - | - | - | - | - | - | - |
| | Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй | 3 | - | - | - | - | 1 | 1 | 1 | - | - |
| | Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй | 1 | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| | Хэмжигдэхүйц биш | 3 | - | - | - | - | 3 | - | - | - | - |
| Биелэлтийн дундаж | | 88.89 | 69.57% | 93.24% | 97.92% | 100% | 92.55% | 91.58% | 80.56% | 80% | 100% |

*Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn*

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжсэн 100 хувьтай 427 заалт, ахиц гарсан-50 хувьтай 45 заалт, тодорхой үр дүнд хүрсэн-50 хувьтай 4 заалт, удаашралтай эрчимжүүлэх шаардлагатай-50 хувьтай 57 заалт, зохион байгуулалтаас-0 хувьтай 5 заалт, санхүү хөрөнгө оруулалтаас-0 хувьтай 2 заалт, хугацаа болоогүй 35 заалт, хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй 1 заалт, хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй 2 заалт, хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй 3 заалт, хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй 1 заалт, хэмжигдэхүйц биш 3 заалт байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр зам, тээврийн салбарт өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг Яамны дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаар гаргаж, үнэлгээг Хүснэгт №9-д харуулав.

*Яамны дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудын хэрэгжилтийн үнэлгээ (Хууль тогтоомж, тогтоол шийдвэр)*

*Хүснэгт №9*

| № | Газрын нэр | Нийт заалт | Үүнээс /хувиар/ | | | | | | | | | | | | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хэрэгжих шатанд | | | Хэрэгжээгүй | | | Хэрэгжих боломжгүй | | | | | |
| | | | Хэрэгжсэн - 100% | Ахиц гарсан - 50% | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Зохион байгуулалтаас - 0% | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй | Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй | Хэмжигдэхүйц биш | |
| 1 | БТГ | 53 | 39 | 3 | 0 | 4 | 1 | 0 | 6 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 90.4 |
| 2 | ТЗУГ | 115 | 100 | 2 | 0 | 7 | 2 | 0 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 1 | 94.1 |
| 3 | ХШҮДАГ | 15 | 12 | 0 | 0 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 90.0 |
| 4 | АЗБЗГ | 107 | 69 | 5 | 1 | 15 | 0 | 1 | 14 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 87.4 |
| 5 | АТБЗГ | 43 | 28 | 3 | 0 | 11 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 83.3 |
| 6 | СХГ | 2 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 75.0 |
| 7 | СХОГ | 39 | 31 | 2 | 0 | 1 | 0 | 0 | 3 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 95.6 |
| 8 | ИНБЗГ | 28 | 17 | 1 | 3 | 4 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 84.0 |
| 9 | ИНЕГ | 7 | 6 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 92.9 |
| 10 | МИАТ | 11 | 10 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| 11 | ТЗГ | 119 | 78 | 23 | 1 | 12 | 0 | 0 | 4 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 84.2 |
| 12 | ТЗТБЗГ | 24 | 13 | 3 | 0 | 6 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 76.1 |
| 13 | ЗТХТ | 3 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 83.3 |
| 14 | АТҮТ | 10 | 9 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 95.0 |
| 15 | УБТЗ | 16 | 13 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 93.3 |
| 16 | МТЗ | 16 | 13 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 93.3 |
| 17 | ТТЗ | 4 | 3 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 87.5 |
| 18 | Далайн захиргаа | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| 19 | Нийт | | 426 | 45 | 6 | 60 | 3 | 2 | 32 | 1 | 2 | 3 | 1 | 3 | 89 |

## 2.5. Сайдын тушаалын хэрэгжилт

Тайлант хугацаанд Зам, тээврийн сайдын тушаалаар яамны нэгжүүд болон харьяа байгууллагуудад 522 үүрэг, даалгавар өгөгдсөн байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 396, хэрэгжих шатанд 38, хэрэгжээгүй 39, хугацаа болоогүй 31, хүчингүй болсон 18 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 87.8 хувьтай байна.

Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь гаргаж, Хүснэгт №10-д харуулав.

*Яамны дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудын хэрэгжилтийн үнэлгээ (Сайдын тушаал)*

*Хүснэгт №10*

| № | Газрын нэр | Нийт заалт | Үүнээс /хувиар/ | | | | | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгжсэн | Хэрэгжих шатанд | Хэрэгжээгүй | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | |
| 1 | ТНБД | 18 | 13 | 0 | 5 | 0 | 0 | 72.22 |
| 2 | БТГ | 20 | 19 | 0 | 0 | 0 | 1 | 100.00 |
| 3 | ТЗУГ | 48 | 37 | 6 | 5 | 0 | 0 | 83.33 |
| 4 | ХШҮДАГ | 110 | 80 | 12 | 11 | 4 | 3 | 83.50 |
| 5 | АЗБЗГ | 54 | 44 | 6 | 2 | 2 | 0 | 90.38 |
| 6 | АТБЗГ | 23 | 19 | 3 | 0 | 1 | 0 | 93.18 |
| 7 | СХГ | 19 | 15 | 3 | 0 | 1 | 0 | 91.67 |
| 8 | СХОГ | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.00 |
| 9 | ИНБЗГ | 67 | 54 | 5 | 3 | 1 | 4 | 91.13 |
| 10 | ИНҮТ | 15 | 10 | 2 | 0 | 1 | 2 | 91.67 |
| 11 | ИНЕГ | 87 | 48 | 4 | 5 | 19 | 11 | 87.72 |
| 12 | МИАТ | 6 | 3 | 0 | 0 | 0 | 3 | 100.00 |
| 13 | АХОЗШША | 4 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 83.33 |
| 14 | ТЗГ | 29 | 23 | 2 | 1 | 2 | 1 | 92.31 |
| 15 | ТЗДТБЗГ | 59 | 48 | 1 | 9 | 0 | 1 | 83.62 |
| 16 | ЗТХТ | 15 | 12 | 0 | 0 | 3 | 0 | 100.00 |
| 17 | АТҮТ | 18 | 17 | 0 | 1 | 0 | 0 | 94.44 |
| 18 | УБТЗ | 34 | 29 | 2 | 2 | 1 | 0 | 90.91 |
| 19 | МТЗ | 32 | 26 | 4 | 0 | 1 | 1 | 93.33 |
| 20 | ТТЗ | 16 | 13 | 2 | 1 | 0 | 0 | 87.50 |
| 21 | Далайн захиргаа | 20 | 17 | 2 | 1 | 0 | 0 | 90.00 |
| 22 | ХХНОБ | 6 | 4 | 0 | 0 | 0 | 2 | 100.00 |
| **Нийт** | | **522** | **396** | **38** | **39** | **31** | **18** | **87.74** |

Зам, тээврийн яам, агентлаг, харьяа байгууллагын хэмжээнд Сайдын тушаалын хэрэгжилт 87.8%-тай байна. Хэрэгжээгүй 39 арга хэмжээ нь томоохон төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажлын явц төсөв, санхүүгийн хүндрэлтэй холбоотой байна.

## 2.6. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт

Тайлант хугацаанд Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар яамны нэгжүүд болон харьяа байгууллагуудад 526 үүрэг, даалгавар өгөгдсөн байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 488, хэрэгжих шатанд 20, хэрэгжээгүй 12, хугацаа болоогүй 3, хүчингүй болсон 3, арга хэмжээний хэрэгжилт дунджаар **95.8** хувьтай байна.

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг яам, агентлаг, газар, нэгж, харьяа байгууллага тус бүрээр авч Хүснэгт №11-т харуулав.

*Яамны дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудын хэрэгжилтийн үнэлгээ (Төрийн нарийн бичгийн даргын тушаал)*

*Хүснэгт №11*

| № | Газрын нэрс | Нийт заалт | Үүнээс /хувиар/ | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгжсэн | Хэрэгжих шатанд | Хэрэгжээгүй | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | |
| 1 | БТГ | 30 | 27 | 2 | 1 | - | - | 93.33 |
| 2 | ТЗУГ | 91 | 87 | 2 | 1 | 1 | - | 97.78 |
| 3 | ХШҮДАГ | 96 | 88 | 6 | 2 | - | - | 94.79 |
| 4 | АЗБЗГ | 104 | 93 | 6 | 4 | 1 | - | 93.20 |
| 5 | АТБЗГ | 26 | 24 | 2 | - | - | - | 96.15 |
| 6 | СХГ | 60 | 59 | - | 1 | - | - | 98.33 |
| 7 | СХОГ | 97 | 92 | 4 | 1 | - | - | 96.91 |
| 8 | ИНБЗГ | 23 | 22 | - | - | 1 | - | 100.00 |
| 9 | ИНЕГ | - | - | - | - | - | - | - |
| 10 | ИНҮТ | 3 | 3 | - | - | - | - | 100.00 |
| 11 | ХХНОБ | - | - | - | - | - | - | - |
| 12 | МИАТ | - | - | - | - | - | - | - |
| 13 | АХОЗШША | - | - | - | - | - | - | - |
| 14 | ТЗДТБЗГ | 40 | 33 | - | 5 | - | 2 | 86.84 |
| 15 | ЗТХТ | 3 | 2 | 1 | - | - | - | 83.33 |
| 16 | АТҮТ | - | - | - | - | - | - | - |
| 17 | Далайн захиргаа | - | - | - | - | - | - | - |
| 18 | УБТЗ | 7 | 7 | - | - | - | - | 100.00 |
| 19 | ТЗГ | 10 | 9 | - | - | - | 1 | 100.00 |
| 20 | ТТЗ | 2 | 2 | - | - | - | - | 100.00 |
| 21 | МТЗ | 2 | 2 | - | - | - | - | 100.00 |
| | **Нийт** | **526** | **488** | **20** | **12** | **3** | **3** | 95.77 |

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам” батлагдсанаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг (хэрэгжсэн), (Хэрэгжих шатанд), (хэрэгжээгүй), (Хугацаа болоогүй), (Хүчингүй болсон) гэсэн үнэлгээгээр үнэлсэн бөгөөд, холбогдох газар нэгж тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүй байна.

## 2.7. Нийтийн мэдээллийн ил тод, байдлын үнэлгээ

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хүснэгт”-ийн дагуу 5 хэсгийн нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг www.shilen.gov.mn сайтад тайлагнаж, хэрэгжилтэд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хяналт тавьж ажиллаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтэд 5 хэсгийн 46 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 93.6 хувьтай байгаа бөгөөд Хүснэгт №12-т харуулав.

*Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт*

*Хүснэгт №12*

| Д/д | Бүлгийн нэр | Үнэлгээний хувь | | | | | Дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 30 | 0 | Хамаа ралгүй | |
| 1. | Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 7 | 3 | - | - | - | 91.0 |
| 2. | Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 4 | 2 | - | - | - | 90.0 |
| 3. | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 11 | 4 | - | - | - | 92.0 |
| 4. | Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал | 2 | - | - | - | - | 100.0 |
| 5. | Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 5 | 1 | - | - | 7 | 95.0 |
| **Нийт** | | **29** | **10** | **-** | **-** | **7** | **93.6** |

*Эх сурвалж: www.shilen.gov.mn*

Тайлант оны жилийн эцсийн байдлаар Зам, тээврийн яамны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 0-70 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 10 арга хэмжээг Хүснэгт №13-т харуулав.

*Зам, тээврийн яамны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт*

*Хүснэгт №13*

| № | Арга хэмжээ | Хэрэгжилт | Үнэл-гээний хувь |
|---|---|---|---|
| Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлтэй байдал | | | |
| 1. | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Яамны сайтад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, танилцуулга, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн тайланг тухай бүр байршуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 5 мэдээлэл шинээр нэмж ажилласан. | 70 |
| 2. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт | Зам, тээврийн салбар үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг тухай бүр сайтад нээлттэй мэдээлэн ажиллаж хэвшсэн болно. | 70 |
| 3. | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | Жил бүр зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөрийг батлуулан, нийтэд мэдээлж ажилладаг. | 70 |
| Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 4. | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, ЗГ-ын 2024 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Ёс зүйн хэм хэмжээний тухай тогтоол болон Төрийн албан хаагчид зориулсан ёс зүйн гарын авлага зэргийг цахим байдлаар сайтад мэдээлсэн ба ёс зүйн дэд хорооны сургалт болон гарын авлагыг тарааж, ажилласан байна. | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/88 дугаар тушаалаар баталсан "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдөр нээлттэй мэдээлж ажилласан. | 70 |
| Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 6. | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл | Нээлттэй мэдээлэл цонхонд https://mrt.gov.mn/i/3480 хуульд заасан нээлттэй байх мэдээ, мэдээллийг байршуулсан. | 70 |
| 7. | Төсвийн хөрөнгөөр болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн | Зам, тээврийн сайдын багцын улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээг 8 удаагийн давтамжтайгаар нээлттэй мэдээлэл цонхонд https://mrt.gov.mn/i/3480 хуульд заасан нээлттэй байх мэдээ, мэдээллийг байршуулсан. | 70 |
| 8. | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан | Нээлттэй мэдээлэл цонхонд https://mrt.gov.mn/i/3480 хуульд заасан нээлттэй байх мэдээ, мэдээллийг байршуулсан. | 70 |
| 9. | Хууль тогтоомжид заасан бусад | Хууль тогтоомжид заасан нээлттэй байх мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. | 70 |
| Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 10. | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт | Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлтийг тухай бүр сайтад мэдээлэн ажилласан | 70 |

Зам, тээврийн салбарын харьяа 12 байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил, тод байдлын хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар тайлагнаж ажилласан, нэгдсэн дүнг Хүснэгт №14-т харуулав.

*Харьяа байгууллагын үнэлгээ*

*Хүснэгт №14*

| № | Харьяа байгууллага | Бүлгийн үнэлгээ (хувиар) | | | | | Дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | I | II | III | IV | V | |
| 1. | ИНЕГ | 88.1 | 64.3 | 70.2 | 61.8 | 67.2 | 74.5 |
| 2. | “ИНҮТ” ТӨХХК | 88.8 | 77.1 | 83.8 | 79.2 | 91.7 | 85.5 |
| 3. | АХОЗШША | 50.0 | 83.3 | 45.3 | - | - | 65.0 |
| 4. | “МИАТ” ТӨХК | 97.3 | 99.4 | 96.5 | 98.9 | 100 | 98.0 |
| 5. | ХХНОБ ТӨХХК | 81.2 | 85.0 | 91.1 | - | 100 | 84.6 |
| 6. | Далайн захиргаа | 68.5 | 73.2 | 83.8 | 75.8 | 48.3 | 73.5 |
| 7. | Төмөр замын газар | 74.4 | 27.4 | 61.5 | 64.2 | 70.8 | 62.1 |
| 8. | “МТЗ” ТӨХК | 95.8 | 88.1 | 98.4 | 90.3 | 89.3 | 93.7 |
| 9. | “ТТЗ” ТӨХХК | 94.2 | 100.0 | 59.9 | 58.3 | 75.0 | 76.5 |
| 10. | “УБТЗ” ХНН | 87.2 | 94.0 | 87.5 | 95.8 | 91.0 | 90.1 |
| 11. | “АТҮТ” ТӨҮГ | 89.0 | 81.0 | 99.0 | 90.2 | 78.1 | 87.5 |
| 12. | “ЗТХТ” ТӨҮГ | 64.4 | 42.8 | 49.0 | 52.8 | 37.5 | 51.1 |

## 2.8. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг тус тус үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулга, стандартын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 92 нэгж, байгууллага байна. Үүнд:

- Улсын төсвийн байгууллага-5;
- Төрийн өмчит үйлдвэрийн газар-31;
- Төрийн өмчит хувьцаат компани-24;
- Хувь нийлүүлсэн нийгэмлэг-1;
- Төрийн өмчит ХХК-24;
- Төсөл, арга хэмжээ-5;
- Засгийн газар, орон нутгийн тусгай сан-2 байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар  Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээлэл байршуулах үүрэг бүхий 92 нэгж, байгууллага нийт тайлагнавал зохих 15,314 мэдээллээс 15,182 мэдээллийг цахим системд байршуулсан ба үүнээс 15,045 мэдээллийг хуульд заасан хугацаанд, 137 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 132 мэдээллийг байршуулаагүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зам тээврийн салбарын хэмжээнд дунджаар 98.2 хувийн биелэлттэй байна.

Үүнээс Зам, тээврийн яамны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2025 оны жилийн эцсийн байдлаар 92.1 хувьтай байна. Хэрэгжилтийг Хүснэгт №15-д харуулав.

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт*

*Хүснэгт №15*

| Байгууллагын нэр | Мэдээлэл оруулах тоо | Мэдээлэл оруулсан тоо | Үүнээс: | | Мэдээлээгүй тоо | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хугацаандаа | Хоцорсон | | |
| Зам, тээврийн яам | 178 | 177 | 164 | 13 | 1 | 92.1 |

## 2.9. Зам, тээврийн Сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт

Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 5 зорилтын 19 арга хэмжээ тусгагдсанаас бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлтэй 12, 50 хувийн биелэлттэй буюу хэрэгжих шатанд 5, 0 хувийн биелэлттэй буюу хэрэгжээгүй 1, хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ **79.4** хувьтай байна. “Гэрээ”-ний хэрэгжилтийг зорилт тус бүрээр гаргаж, Хүснэгт №16-д харуулав.

*Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт*

*Хүснэгт №16*

| № | Зорилт | Нийт | Үнэлгээ (хувиар) | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгж сэн | Хэрэгжих шатанд | Хэрэг жээгүй | Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | Хэрэгжих боломжгүй | |
| 1. | 1-р зорилт | 4 | 2 | 1 | 1 | - | - | 62.5 |
| 2. | 2-р зорилт | 8 | 5 | 3 | - | - | - | 81.2 |
| 3. | 3-р зорилт | 1 | - | - | - | - | 1 | - |
| 4. | 4-р зорилт | 3 | 3 | - | - | - | - | 100.0 |
| 5. | 5-р зорилт | 3 | 2 | 1 | - | - | - | 83.3 |
| Нийт | | 19 | 12 | 5 | 1 | - | 1 | **79.4** |

Тайлант оны жилийн эцсийн байдлаар “Гэрээ”-нд тусгагдсан 19 арга хэмжээнээс цаашид эрчимжүүлэн ажиллах шаардлагатай “0-50” хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээг Хүснэгт №17-т харуулав.

*“0-50” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ*

*Хүснэгт №17*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Үнэлгээ (хувиар) | Хариуцсан нэгж |
|---|---|---|---|
| 1 | 2.Дүүжин тээвэр төслийн 1-р шугам буюу "Яармаг, Арцат - Өнөр хороолол" шугамын бүтээн байгуулалтын үргэлжлүүлнэ. | 50 | АТБЗГ |
| 2 | 3. Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлнэ | 0 | АТБЗГ |
| 3 | 5."Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна. | 50 | АЗБЗГ |
| 4 | 6.Хөшигийн хөндийн туннелийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна. | 50 | АЗБЗГ |
| 5 | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4, 23- хороо Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох авто замын Наадамчдын гудамжны авто зам дээгүүр шинээр гүүрэн байгууламж барина. | 50 | АЗБЗГ |
| 6 | 17. Авто замын сүлжээний арчлалт, урсгал засварын ажлын төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно | 50 | АЗБЗГ |

“Гэрээ”-г хамтран хэрэгжүүлэхээр давхардсан тоогоор 38 арга хэмжээг авч үзэхэд бүрэн хэрэгжсэн 23, хэрэгжих шатанд буюу 50 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжээгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 2, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 2, хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **80.0** хувьтай байна.

Эдгээр нэгж, байгууллагуудын хариуцсан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээг доорх Хүснэгт №18-т харуулав.

*Арга хэмжээний дундаж үнэлгээ*

*Хүснэгт №18*

| № | Хариуцах газар | Нийт | Үнэлгээ (хувиар) | | | | | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгж-сэн | Хэрэгжих шатанд | Хэрэг-жээгүй | Хугацаа болоогүй | Хэрэгжих боломжгүй | |
| 1 | Нийслэл | 18 | 11 | 5 | 1 | 1 | - | 79.4 |
| 2 | АЗБЗГ | 10 | 6 | 4 | 0 | 0 | - | 80.0 |
| 3 | АТБЗГ | 7 | 4 | 1 | 1 | 1 | - | 75.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | ТЗДТБЗГ | 3 | 2 | - | - | - | 1 | 100 |
| **Нийт** | | **38** | **23** | **10** | **2** | **2** | **1** | **80.0** |

Зам, тээврийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд нийт 473 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 247, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 165, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 26, хэрэгжих боломжгүй буюу үнэлгээнд тооцох боломжгүй 38 арга хэмжээ, дунджаар **75.4** хувьтай үнэлэгдсэн байна. Биелэлтийг аймаг тус бүрээр гарган Хүснэгт №19-т харуулав.

*Аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилт*

*Хүснэгт №19*

| № | Аймаг | Нийт | Үнэлгээ (хувиар) | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 50 | 0 | Хэрэгжих боломжгүй | |
| 1. | Архангай | 18 | 11 | 4 | 3 | - | 72.2 |
| 2. | Баян-Өлгий | 21 | 16 | 5 | - | - | 88.1 |
| 3. | Баянхонгор | 24 | 9 | 8 | 1 | 6 | 72.2 |
| 4. | Булган | 26 | 10 | 13 | 1 | 2 | 62.5 |
| 5. | Говь-Алтай | 19 | 9 | 10 | - | - | 73.6 |
| 6. | Говьсүмбэр | 20 | 12 | 8 | - | - | 80.0 |
| 7. | Дархан-Уул | 20 | 12 | 6 | 2 | - | 75.0 |
| 8. | Дорноговь | 20 | 14 | 5 | - | 1 | 86.8 |
| 9. | Дорнод | 28 | 19 | 9 | - | - | 83.9 |
| 10. | Дундговь | 20 | 9 | 7 | 1 | 3 | 73.5 |
| 11. | Завхан | 23 | 7 | 15 | - | 1 | 65.9 |
| 12. | Орхон | 19 | 11 | 3 | 1 | 4 | 83.3 |
| 13. | Өвөрхангай | 20 | 10 | 5 | 2 | 3 | 73.5 |
| 14. | Өмнөговь | 25 | 17 | 6 | 1 | 1 | 83.3 |
| 15. | Сүхбаатар | 26 | 6 | 11 | 1 | 8 | 63.9 |
| 16. | Сэлэнгэ | 24 | 21 | 3 | - | - | 93.7 |
| 17. | Төв | 21 | 7 | 12 | 2 | - | 61.9 |
| 18. | Увс | 24 | 16 | 4 | - | 4 | 90.0 |
| 19. | Ховд | 26 | 10 | 10 | 4 | 2 | 62.5 |
| 20. | Хөвсгөл | 22 | 8 | 13 | 1 | - | 65.9 |
| 21. | Хэнтий | 27 | 13 | 8 | 3 | 3 | 70.8 |
| **Нийт** | | **473** | **247** | **165** | **23** | **38** | **75.4** |

Зам, тээврийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн үнэлгээний хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувиар өссөн байна. 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт Сэлэнгэ аймаг хамгийн сайн буюу 93.7 хувиар үнэлэгдсэн бол Төв аймаг хамгийн бага буюу 61.9 хувиар үнэлэгдсэн байна.

## 2.10. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад эрх бүхий байгууллагаас 2025 онд хийсэн хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн бөгөөд Хүснэгт №20-д харуулав.

Энэхүү үнэлгээг хяналт-шинжилгээ үнэлгээний тайланд тусгаагүй болно.

*Хяналт шалгалт болон аудитын
тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт*

*Хүснэгт №20*

| Д/д | Эрх бүхий байгууллага | Зөвлөмжийн агуулга | Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийт | Үүнээс | | |
| | | | | Хэрэгжсэн | Хэрэгжээгүй | |
| 1 | ҮАГ | Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 3 | 2 | 1 | 67% |
| 2 | ҮАГ | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 3 | 1 | 2 | 33% |
| 3 | ҮАГ | Зам, тээврийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /Яамны аппарат/ | 21 | 9 | 12 | 43% |
| 4 | ҮАГ | Зам, тээврийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /Төсвийн ерөнхийлөн захирагч/ | 12 | 3 | 9 | 25% |
| 5 | ҮАГ | Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 3 | 3 | 0 | 100 |
| 6 | ЗГХХГ | Зам, тээврийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 11 | 2 | 9 | 18% |
| 7 | ЗТЯ | Зам, тээврийн яамны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 14 | 2 | 12 | 14% |
| 8 | ЗТЯ | Зам, тээврийн яамны төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах хөтөлбөрийн биелэлтэд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 9 | 9 | 0 | 0% |
| **Нийт** | | | **76** | **31** | **45** | **37.5** |

Цаашид Зам, тээврийн салбарын хэмжээнд Үндэсний аудитын газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хяналт-шинжилгээ үнэлгээ болон хяналт, шалгалтын “зөвлөмж”-ийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

## 2.11. Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар Зам, тээврийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт салбарын хэмжээнд “эрсдэлийн удирдлага”-ыг салбарын хэмжээнд хууль тогтоомж, нэгдсэн бодлоготой уялдуулан хэрэгжилтийг зохион байгуулах,

зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгуулсан.

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/158 дугаар тушаалаар баталсан албан тушаалын тодорхойлолтод эрсдэлийн удирдлагын чиг үүргийг тусгаж, Эрсдэлийн асуудал хариуцсан албан хаагчийг томилсон. Уг үйл ажиллагааг 2026 оноос зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

## 2.12. Байгууллагын ажилтан албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын гуравдугаар хавсралтын дагуу “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын monitoring@ags.gov.mn цахим хаягт хүргүүлсэн.

Зам, тээврийн яамны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлт 2025 оны жилийн эцсийн байдлаар **95.7** хувийн хэрэгжилттэй байна. Хөтөлбөрт туссан 7 зорилтын хэрэгжилтийн үнэлгээг Хүснэгт №21-д харуулав.

*“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлт*

*Хүснэгт №21*

| № | Үйл ажиллагаа | Хэрэгжилт /хувиар/ |
|---|---|---|
| 1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | |
| 1 | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 100 |
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 100 |
| 3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 100 |
| 2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | |
| 4 | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 90 |
| 5 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 90 |
| 6 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 100 |
| 7 | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 90 |

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын гуравдугаар хавсралтад заасны дагуу нэгтгэж, Хүснэгт №22-т харуулав.

*Байгууллагын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт*

*Хүснэгт №22*

| Д/д | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорил-тот | Хүр-сэн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад | 1.1 | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 13 | 17 | Яамны албан хаагчдын “Сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (**дотоод сургалт)** | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | 4 | 6 | сургалтын төлөвлөгөөг /2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр/ Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 17 төрлийн сургалтад давхардсан тоогоор яамны 167, харьяа байгууллагын 20, нийт 187 албан хаагч хамрагдсан. Үүнээс мэргэшүүлэх сургалтад 38, бусад сургалтад 129, гадаадын богино хугацааны сургалтад 22, Гадаадын их дээд сургуулийн магистрын тэтгэлэгт 1, дотоодын их дээр сургуульд 2 албан хаагч суралцсан. Тухайлбал:<br>- “Мэдээллийн аюулгүй байдлын менежмент” сэдэвт сургалтад яамны 15, харьяа байгууллагын 20 албан хаагч хамрагдаж сертификат авсан,<br>-"И-Монгол" академийн сургагч багш нар мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр болон компьютер, мэдээллийн системийн зохистой хэрэглээ сэдэвт сургалтад 15 албан хаагч,<br>- “ Авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хор нөлөөл” сэдэвт сургалтыг Авлигатай тэмцэх газраас ажлын байран дээр зохион байгуулж 80 албан хаагч,<br>- АХБ-ны санхүүжилтээр зохион байгуулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит ба iRAP-ийн үе шаттай сургалтад мэргэжлийн чиглэлийн 18 албан хаагч хамрагдаж сертификат авсан,<br>- “Кибер аюулгүй байдлын тухай” сэдэвт |
| | | | Мэргэшүүлэх сургалт | 5 | 9 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | - | - | |
| | | | Бусад | 3 | 2 | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 90 | 167 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | 71 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | 113 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 10 | 11 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 80 | 156 | |
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: (Нийт албан хаагчдад эзлэх хувь) | 60-аас дээш | 85% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад нийт албан хаагчид,<br>- Төрийн нарийн бичгийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу тус яамны хуулийн хэлтсээс зохион байгуулсан Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн алба дахь Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн дотоод журам сэдэвт сургалтад 40 албан хаагч тус тус хамрагдсан. |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан **(гадаад сургалт)** | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | - | 15 | - |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | - | 23 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | 10 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | 13 | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | 3 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | 20 | |
| | | 2.3 | Гадаад сургалтад хамруулсан байдал: | 20-оос дээш | 23 | |
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал | 3.1 | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 4,954,950 /дөрвөн сая есөн зуун тавин дөрвөн мянга есөн зуун тавин/ | | |
| 4. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 4.1 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх) | *Тайлант хугацаанд 9 албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлж, 3 албан хаагчийг ажлаас чөлөөлж, өндөр насны тэтгэвэрт тогтоолгох насанд хүрсэн 2 албан хаагчийг тус тус төрийн албанаас чөлөөлсөн. Нийт 14 албан хаагчийг чөлөөлсөн байна. Шилжилт хөдөлгөөний хувь (14/125)*100%=11.2 хувь* | | |
| | | 4.2 | Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо | - | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | |
| | | 4.3 | Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо | - | Зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулсантай холбоотой 21 албан хаагчийг төрийн өөр байгууллага хооронд шилжүүлж, 2 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан байна. |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 10 | - |
| | | | Эрэгтэй албан хаагч | 13 | - |
| | | | Удирдах албан тушаалтан | - | 1 |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | 22 |
| Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ | | | | | |
| 5. | Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг | | | - | Тайлант оны гүйцэтгэлээр |
| | **5.1.Улирлын урамшуулал олгосон байдал** | Нийт албан хаагчийн тоо | | 224 | 430,178,500.00 |
| | | Урамшуулал олгосон албан хаагчийн тоо | | - | - |
| | | Үүнээс | удирдах | 26 | - |
| | | | гүйцэтгэх | 198 | - |
| | | Нийт олгосон урамшууллын хэмжээ | | - | - |
| | | Үүнээс | I улирал | - | - |
| | | | II улирал | 112 | 210,349,500.00 |
| | | | III улирал | - | - |
| | | | IV улирал | 112 | 219,829,000.00 |
| | | Цалингийн нийт санд эзлэх хувь | | - | 7.46 хувь |
| | **5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:** | албан хаагчийн тоо | | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | - | |
| | 5.2.1.дотоод албан томилолтоор ажиллах үеийн зардал | | албан хаагчийн тоо | 271 | - |
| | | | зардлын хэмжээ | | 184,407,210₮ |
| | 5.2.2. гадаад албан томилолтоор ажиллах үеийн зардал | | албан хаагчийн тоо | 21 | - |
| | | | зардлын хэмжээ | | 147,619,889.18₮ |
| | 5.2.3. албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх | | албан хаагчийн тоо | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | явцад эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.4. албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 3.2) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.5.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 7.1) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 6.1) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | **5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:** | албан хаагчийн тоо | | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | |
| | 5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2, 8.4) | албан хаагчийн тоо | 1345 | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 1,005,982,049.277 |
| | 5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.3) | албан хаагчийн тоо | 1 | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 300,000 |
| | 5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн | албан хаагчийн тоо | | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.5) | | | |
| | 5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.6) | албан хаагчийн тоо | | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | - |
| | **5.4 Албан хаагчид олгосон тусламж, нийт:** | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж | албан хаагчийн тоо | 2 | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 105,101,260.38 |
| | 5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | **5.5. Албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:** | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон | албан хаагчийн тоо | 8 | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 42,656,532₮ |
| | 5.5.2.орон байраар хангагдахад байгууллагаас үзүүлсэн дэмжлэг | албан хаагчийн тоо | - | - |
| | | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | - |
| | 5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 5.5.4.албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш | албан хаагчийн тоо, зарцуулсан хөрөнгийн | 114 | Хиймэл оюун ухаанд суурилсан бүтэн биеийн оношлогоонд тус яамны 114 албан хаагчийг хамруулж, 15,400,000 төгрөгийг зарцуулсан байна. |

## 3. Үнэлэлт, дүгнэлт:

3.1. Зам, тээврийн яамны 2025 оны үйл ажиллагаанд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”,"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн Хүснэгт №1-д заасан байдлаар үнэлсэн.

3.2. Зам, тээврийн яамны үйл ажиллагааны тайлангийн үнэлгээнээс харахад 2025 оны жилийн эцсийн байдлаар 10 үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлэх 2553 арга хэмжээний хэрэгжилт 83.8 хувьтай байна.  Арга хэмжээний хэрэгжилтийн жигнэсэн дундаж үнэлгээ 80.9 хувьтай байгаа нь өндөр жин бүхий Бодлогын баримт бичиг болон Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний  хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Жигнэсэн дундаж үнэлгээг дараах томъёоны дагуу бодсон.

$$\text{Жигнэсэн дундаж} = \frac{\sum(\text{Хэрэгжилтийн хувь} * \text{Жин})}{\sum \text{Жин}}$$

3.3. Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 12 зорилтын 90 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 80.4 хувьтай үнэлэгдсэн бөгөөд өмнөх оноос 0.37 хувиар өссөн үзүүлэлттэй, Яамны үйл ажиллагааны тайлан 83.8 хувьтай байгаа бөгөөд өмнөх оноос 1.21 хувиар өссөн үзүүлэлттэй  байна.

3.4. Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 12 зорилтын 90 арга хэмжээний шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшинг алдаатай тодорхойлсонтой холбоотой нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь яамны төлөвлөгөөнөөс хүрэх түвшин багассан, хэрэгжих хугацааг хойшлуулсан зэрэг алдаа гарсан байна.

## Дөрөв. Санал, зөвлөмж

Зам, тээврийн яамны 2025 оны үйл ажиллагааны тайланд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

4.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан төсөл арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан, дэд салбар тус бүрээр үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж Бодлого, төлөвлөлтийн газарт тайлагнаж хэвшихийг Бодлого, зохицуулалтын газруудад;

4.2. Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тасарсан буюу 0 хувийн биелэлттэй 1, 30 хувийн биелэлттэй 11 арга хэмжээ, 50 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй Хүснэгт №7-д заасан арга хэмжээ болон Яамны  2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд багцалж, төлөвлөсөн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж

ажиллаагүй тул яамны бүх газрууд хэрэгжилтийг бүрэн хангах ажлыг зохион байгуулж, Төрийн захиргааны удирдлагын газарт тайлагнаж, хэвшихийг Яамны газар, хэлтэст;

4.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг сар, улирал, хагас бүтэн жилээр болон тухай бүр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний new.unelgee.gov.mn-д тайлагнах тул Бодлого зохицуулалтын газрууд дэд салбар тус бүрээр хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган эзэнжүүлж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан, Төрийн захиргааны удирдлагын газарт тайлагнаж, хэвшихийг Яамны газар, хэлтэст;

4.4. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2023, 2024, 2025 онуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, бүрэн хэрэгжсэн боловч хяналтаас хасагдаагүй байгаа арга хэмжээг хяналтаас хасах, гадаад, дотоод томилолтоор ажилласан тохиолдолд холбогдох журамд заасан хугацаанд тайланг гаргаж хэвшихийг Яамны газар, хэлтэст;

4.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажлын хүрээнд Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам” болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн shilen.gov.mn-д улирал тутам үнэн зөв мэдээлэл байршуулж хэвшихийг Яамны бүх газар, хэлтэст;

4.6. Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журамд заасны дагуу https://shilendans.gov.mn/ цахим сайтад холбогдох мэдээллийг байршуулахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газарт;

4.7. Зам, тээврийн сайд, аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгах санхүү, хөрөнгө оруулалт шийдэж хийгдэх арга хэмжээний саналыг тухайн жилийн улс болон орон нутгийн төсөв батлагдахаас өмнө аймгуудад хүргүүлж хэвших, Бодлого зохицуулалтын газрууд хэрэгжилтийн байдалд хагас бүтэн жилээр хяналт тавьж, бүрэн тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлж хэвших;

4.8. Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан журмын зургаадугаар хавсралтаар баталсан “Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмж”-ийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн тайлагнаж хэвшихийг Яамны газар, хэлтэст;

4.8.1. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл “Төрийн аудитын тайлан” хэсэгт заасны дагуу аудитын дүнд үндэслэн гарсан “зөвлөмж”-ийг хүлээж авсан Газар, хэлтэс “зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан зөвлөмжид заасан хугацаанд Аудитын байгууллагад хүргүүлж хэвших;

4.9. Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх тухай” 03 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-д нийцүүлэн Бодлого, зохицуулалтын газрууд дэд салбар бүрийн хууль тогтоомж, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн эрсдэлийг удирдах нэгдсэн төлөвлөгөөнд тусгах саналыг Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэн, тус газраас эрсдэлийг удирдах нэгдсэн

төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангуулж, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт тайлагнаж хэвших;

4.10. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх зардлыг тооцон, төсөвт тусган батлуулж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, үр дүнг нийт албан хаагчдад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөрт багтаан тайлагнаж, 2027 оноос шинээр хэрэгжих хөтөлбөрийн төслийг боловсруулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

4.11. Албан хаагч бүр өөрийн хариуцсан арга хэмжээг тоо баримттай, 2000 тэмдэгтэд багтаан, заасан хугацаанд бүрэн тайлагнах, нэгжийн дарга нар тэдгээр арга хэмжээг бүрэн хянаж, баталгаажуулан ажиллахыг тус тус зөвлөж байна.

---o0o---